

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР (2025 оны жилийн эцсийн байдлаар)

№	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дэд зорилт	Хүрсэн түвшин (Биелэлт)	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
1.1.Хот, суурин газрын иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.			
1	1.1.1.“Нэг төвт хотоос олон төвт хот”-ын тогтолцоог бүрдүүлж Нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулах орон нутгийн зэрэглэлтэй Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Шинээр байгуулагдах хотуудын эдэлбэр газрын хил хязгаарыг тогтоох асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэхтэй холбогдуулан “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолыг дагаж мөрдөх хугацааг 2027 оны 01 дүгээр сарын 01 хүртэл хойшлуулсан.	00.0
2	1.1.2.Баянхошуу, Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.	<p>"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр":.</p> <p><u>Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд:</u></p> <p>Баянхошуу дэд төвд 5 нийгмийн барилга байгууламж, 2 инженерийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэхээс 5.8 км дулааны шугамын ажил бүрэн дууссан. УДДТ-2, дулааны насос станц 1, хаалттай дэд өртөө 2, 3.4 км дулааны шугам, 2.4 км усан хангамж, 0.3 м бохирын шугамын барилгын ажлын явц 91.3 хувьтай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Аврах гал унтраах 29 ангийн барилгын ажил 60.2 хувь; - Спорт цогцолборын ажил 85 хувь; - Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн 60.6 хувь; - Олон нийтийн хөгжлийн төв 38 хувь; - 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 42.3 хувьтай байна. <p><u>Төслийн 3 дугаар үе шатны хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Авто зам 6.02 км - Дулааны шугам 6.1 км - УДДТ 5ш - Бохир усны шугам 8.9 км - Цахилгааны шугам 56.4 км 	25.0

		<ul style="list-style-type: none"> - Холбооны шугам 6.7 км - Цэвэр усны шугам 7.5 км-33.3 хувь - Үерийн хамгаалалтын суваг 6.9 км-95 хувь - Сургалтын төвийн барилга угсралт-100 хувь - 42 дугаар сургуулийн барилгын өргөтгөл-60.6 хувь - Мэдээлэл холбооны төв-100 хувь - 4га газрын тохижилт, ногоон байгууламж-15 хувьтай хийгдэж, тухайн бүтээн байгуулалтын нөлөөлөлд нийт 530 айл өрх өртсөнөөс 522 айл өрхөд нөхөн олговрыг олгосон. 	
3	1.1.3.“Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл”-ийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	<p>Дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 99,920 м2 газарт "Орлогод нийцсэн орон сууцны төсөл"-ийн хэрэгжүүлэгчээр “Сайхан төмөрт” ХХК шалгарсан.</p> <p>Тус хорооллын төлөвлөлт:</p> <ul style="list-style-type: none"> - Зоорьтой 9 давхар, 13 блок 1764 айлын орон сууц - 11 блок амины сууц /single house, town house/ 16 - 320 хүүхдийн сургууль - 200 хүүхдийн ортой цэцэрлэг - Ногоон байгууламж <p>Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар ус, цахилгаан, дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэр, бохир усны шугамын ажлууд хийгдсэн. Эхний 2 барилга нь зоорийн давхар болон 6 давхар хүртэлх барилга угсралтын ажил хийгдсэн. Баянголын аманд 10га талбайд БНСУ-ын Эксим банкны жилийн 0.15 хүүтэй 114.7 сая ам/дол-ын зээлийн санхүүжилтээр орлогод нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй, 10 давхар, 14 блок 2007 айлын орон сууцны хорооллыг барих төлөвлөлттэй. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр “Ил сонг” ХК шалгарч, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 5, төслийн нийт гүйцэтгэл 25 хувьтай явагдаж байна.</p>	25.0
4	1.1.4.Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээврийг шинэчилж, иргэдийн ая тухтай аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 18, 29 дүгээр хороонд 3 байрны нийт 7 цахилгаан шатыг шинэчлэн засварлах ажлыг “ОАКС Mongolia” ХХК хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 12, 14, 15, 17 дугаар хороодын 11-н байрны 21 орцны дээвэр засварын ажил хийгдсэн. 18, 19, 20, 27, 29 дүгээр хороодод 11-н байрны дээвэр засварын ажил тендер шалгаруулах шатандаа. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 38 дугаар хорооны 53 дугаар байр, 20 дугаар хорооны 29 дүгээр байрны дээвэр засвар ажил хийгдэж дууссан.</p>	25.0
5	1.1.5.Орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	<p>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13, 16, 18 дугаар хороодод 3-н байрны фасад засварын ажлын гүйцэтгэл 90 хувь, 14, 19, 20, 27 дугаар хороодод 4-н байрны фасад засварлах ажил 70 хувьтай хийгдэж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хорооны Нефьт 1/30 байрны фасад засварын ажил 50 хувьтай явагдаж байна.</p>	20.0

6	1.1.6.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулна.	Дүүргийн хэмжээнд 7 хорооны 28 ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилга байна. Үүнээс 2 хорооны 5 байршилд гүйцэтгэгч сонгон шалгарч, 6 хорооны 23 байршилд гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг нийслэлийн Засаг даргаас “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д шилжүүлсэн байна. 18 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч “Хур алтан өргөө” ХХК нь 2 дугаар багц ажлын хүрээнд 5 дугаар байрыг буулган, барилгын ажлыг эхлүүлсэн, ажлын явц 70 хувьтай ажил удааширсан. Станцын 4 дүгээр байрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг нийслэлийн Засаг даргын захирамжаар цуцалж, дахин барилгажуулах ажлыг зохион байгуулахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д даалгаж, тендерт “Гартаам агат” ХХК шалгарч, барилгын ажил 60 орчим хувьтай байна. Гадна шугам сүлжээний ажлыг “Н Эй Би Групп” ХХК гүйцэтгэж, ажлын явц 80 орчим хувьтай. Дүүргийн 19 дүгээр хорооны ашиглалтын шаардлага хангахгүй 3-20 дугаар дан байрны төсөл хэрэгжүүлэгчээр “Очир бумбат констракшн” ХХК шалгарсан. Үйлчилгээний талбай бүхий 1 блок 16 давхар 132 айлын орон сууцны барилгын төлөвлөлттэй. Барилга угсралтын ажил 13 давхарт явагдаж байна.	25.0
1.2.Дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, авто зам, замын байгууламж, гэрэлтүүлэг, инженерийн шугам сүлжээний хүчин чадал, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэлийг бууруулна.			
7	1.2.1.Гэр хорооллын цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбоно.	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 31 дүгээр хороонд 1 байршил, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 21, 28, 32, 33, 35, 36, 41 дүгээр хороодод нийт 14 байршилд цахилгаангүй айл өрхийн хүчдэл сайжруулах ажил хийгдсэн. Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 дүгээр хороонд 0.4 кВт цахилгаан дамжуулах шугамын ажил хийгдсэн. 21 дүгээр хорооны Рашаантын 47 айл өрхийг эрчим хүчээр хангах, хүчдэл сайжруулах шаардлагатай хүчдэлийн зураг, төсвийг хийлгэхээр Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д албан бичиг хүргүүлсэн.	20.0
8	1.2.2.Хотын хөдөлгөөний эрчим их гол гудамж замуудын уулзваруудад олон түвшний огтлолцол бүхий авто зам барих ажлыг үргэлжлүүлнэ.	Толгойтын замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох 3.9 км авто замын явган зам, далангийн хөвөөг хэлбэржүүлэх, ус зайлуулах лотки суулгах тохижилтын ажил хийгдэж байна.	20.0
9	1.2.3.Тээврийн хэрэгслийн давхар зогсоолыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулан, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зөвшөөрөлгүй баригдсан хашаа, гарааш буулгасан талбайд авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж 18, 19, 27, 29 дүгээр хороодод 6536 м2 авто зогсоолыг шинээр байгуулсан.	15.0

10	1.2.4.Орон сууцны хорооллын доторх хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлтийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороодын орон сууцны хорооллын дундах 27,200 м2 авто замын засварын ажлыг “Баруун бүсийн зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн. Дүүргийн орон сууцны хороолол доторх хатуу хучилттай автозамуудын нөхөөс, засвар шинэчлэлийн ажлыг хийх саналыг нийслэлийн замын хөгжлийн газарт албан бичгээр уламжлан, 2026 оны төсөвт суулгуулах саналаа хүргүүлэн ажилласан.	25.0
11	1.2.5.Баруун бүсийн зам засвар арчлалт хариуцсан ОНӨААТҮГ байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.	Дүүргийн Засаг даргын “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг батлах тухай А/45 дугаар захирамжийн хүрээнд “Баруун бүсийн зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ыг байгуулан, Улаанбаатар зам арчлалтын газраас 51 техник, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Дүүргийн 21, 24 дүгээр хорооны Баруун, Зүүн салаа, Ар гүнтэд 9500 м2 авто замын хучилт, 20, 32 дугаар хорооны Эмээлт, Монгол наадам цогцолбор, Цэргийн хотхонд нийт 3880 м2 авто замын нөхөөс, 19 дүгээр хороо Тесо-гийн уулзвар, 33 дугаар хороо Тахилтын нүхэн гарц, 18 дугаар хороо, 4 дүгээр хороо Мик-ийн гудамж, 11 дүгээр хороо Баянхошууны Хайлааст салдаг уулзвар хүртэлх авто болон явган замуудын нөхөөс, хэвтээ тэмдэглэгээ 273 м2, босоо тэмдэглэгээ 16 ширхэгийг хийж гүйцэтгэсэн байна.	100.0
12	1.2.6.Авто зам, замын байгууламжийг ус зайлуулах инженерийн шугам сүлжээтэй барьж байгуулан, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагчийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 32 дугаар хороонд 2.6 км авто зам, 6 ус зайлуулах хоолой, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 34 дүгээр хороонд 16 км авто зам, 5 ус зайлуулах хоолой хийгдсэн. Дүүргийн хэмжээнд 43 хорооны 90 байршилд 250 ширхэг, 8 сургууль (9, 42, 62, 122, 124, 134, 151, 153), 6 цэцэрлэгт (81, 91, 170, 215, 228) нийт 14 байршилд 956м2 хурд сааруулагч, цагаан зураасын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн засварлуулах ажлыг холбогдох хэлтэстэй хамтран зохион байгуулсан.	25.0
13	1.2.7.Гэр хорооллын авто замуудын нөхцөлийг сайжруулна.	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 32 дугаар хорооны “Хурганы зам”-ын хатуу хучилттай 2.6 км авто зам 100 хувь, 11, 31, 39, 43 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2.1 км авто замын ажил 90 хувь, 35 дугаар хороонд 2.6 км авто замын ажлын явц 90 хувьтай хийгдэж байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 34 дүгээр хороо, Орбитын тойргоос Найрамдал зуслан хүртэл 16 км авто замын ажил гүйцэтгэсэн. Дэлхийн банкны санхүүжилтээр дүүргийн 13 хорооны нутаг дэвсгэрээр дамжсан 8.4 км иж бүрэн авто замын гүйцэтгэгч “Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгж” хийж, ажлын явц 40 хувьтай байна. Толгойтын гудамжнаас Ард Аюушийн өргөн чөлөө хүртэлх 3.6 км замын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй хөдөлгөөн нээгдэж, тохижилтын ажил хийгдэж байна. Дүүргийн гэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн хусаж тэгшлэх ажлын гүйцэтгэгч “Дэд бүтэц хөгжлийн алба” ОНӨААТҮГ хийж, 33 хорооны 550 гудамжинд хайрга дайрга асган, 1.7 сая м2 талбайг хусаж тэгшилсэн.	25.0

14	1.2.8.Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор шаардлагатай байршлуудад нүхэн болон гүүрэн гарц байгуулна.	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Энхтайваны өргөн чөлөө, Үйлдвэрчний эвлэлийн гудамжны уулзвараас Баянгол дүүргийн 20 дугаар хороо нэвтрэх хэсэгт нүхэн гарц, гадна талбайн тохижилтын ажил хийгдсэн. 2026 онд Толгойтын гудамжнаас Ард Аюушийн өргөн чөлөө хүртэлх 6 эгнээ автозамд 2 байршилд, 21 дүгээр хороололд 1 байршилд, Залуус хорооллын урд замд 1 байршилд нийт 4 байршилд гүүрэн болон нүхэн гарц хийхээр санал төлөвлөөд байна.	10.0
15	1.2.9.Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллын гудамжийг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 42 дугаар хорооны Хайрхан 18, Одонт 29, 30 дугаар гудамжинд 55 ширхэг гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 4, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 70 ширхэг гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 дугаар хороонд 6 цамхагт гэрэлтүүлэг хийсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 дугаар хороонд Спорт цогцолборын хөл бөмбөгийн талбайд 17 ширхэг цамхагт, 45 ширхэг нарны панель бүхий явган замын гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 35, 43 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 343 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэнээс Цамхагт гэрэлтүүлэг 23 ширхэг, Нарны панель бүхий явган замын гэрэлтүүлэг 86 ширхэг, Авто замын гэрэлтүүлэг 70 ширхэг, Орон сууц болон гэр хорооллын гудамжинд 164 ширхэг гэрэлтүүлгийг тус тус суурилуулсан.	25.0
16	1.2.10.Үерийн болон булаг шандын ус, хөрсний ус нэвчилтээс хамгаалсан далан суваг, ус зайлуулах инженерийн шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ.	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 560 м үерийн хамгаалалтын далан суваг, 22 дугаар хороонд дулааны шугамыг инженерийн шугамд холбох ажлын явц 85 хувьтай, 26 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн гадна бохир ус, цооногийн ажил, 24, 25, 33 дугаар хорооны нутаг үерийн далан, авто машины орц гарцыг хийж гүйцэтгэсэн. 30 дугаар хорооны 125 дугаар цэцэрлэгийн ус зайлуулах шугамын ажил цуцлагдсан. 6 дугаар хорооны үерийн ус зайлуулах хоолойн зураг төслийн ажил хийгдэж байна.	20.0
17	1.2.11.Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох, ухаалаг төхөөрөмж суурилуулах, гүний худгийг тоолууржуулж, усны алдагдлыг бууруулна.	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 21, 32 дугаар хороодод 4 усан сан баригдаж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 23 дугаар хороонд 2 зөөврийн ус түгээх байр баригдах байршлыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-аас зөвшөөрөөгүй улмаас цуцлагдсан. Дүүргийн хэмжээнд нийт 244 усан сан байгаагаас зөөврийн усан сан 157, ухаалаг худаг 87, гүний худаг 1 үйл ажиллагаа явуулж байна.	20.0
18	1.2.12.Нийтийн тээврийн хүртээмжгүй бүсэд том болон дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлнэ.	Дүүргийн 10, 24, 28, 30, 32, 33, 35, 39 дүгээр хороодод шинээр авто зам болон сургууль, цэцэрлэг баригдсантай холбогдуулан бага оврын автобусны чиглэлийг нэмэгдүүлэх саналуудыг нэгтгэн Нийтийн тээврийн бодлогын газарт 3 удаа албан бичгээр уламжласан. Дүүргийн 10 дугаар хороонд богино эргэлтийн чиглэлд автобусны хүртээмжийг нэмэгдүүлэх, 24 дүгээр хорооны сургуулийн бүсэд дунд оврын автобусны чиглэлийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.	05.0

1.3.Газар зохион байгуулалттай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.			
19	1.3.1.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөнд 4 бүлгийн 208 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас газрын менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр 40 ажил, газар зохион байгуулалтын чиглэлээр 104 ажил, газрын зөрчил арилгах, газрын байршил, хэмжээтэй холбоотой 48 ажил, газрын төлбөрийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр 16 ажил тус тус тусгагдсан. Дүүргийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт тайлант хугацаанд 90 хувьтай хэрэгжиж байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан. Тогтоолын хавсралтад нийт 2 бүлгийн 7 дэд бүлэгт хамаарах 53 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас газрын менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр 2 ажил, газар зохион байгуулалтын чиглэлээр 53 ажлыг тусган хэрэгжүүлж ажиллаж байна.	25.0
20	1.3.2.Эзэмшил газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхэнд хяналт тавьж газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгож дахин хуваарилалтад оруулна.	Дүүргийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар 7 иргэн, 2 хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон. 51 иргэн, 1 хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу сонсох ажиллагааг явуулж Засаг даргын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох захирамжийн төсөлд бэлтгэж байна.	15.0
21	1.3.3.Бүтээн байгуулалт болон эрсдэл бүхий байршилд газрыг чөлөөлж, шаардлагатай нөхцөлд нөхөн олговор олгоно.	Дүүргийн 4, 5, 26, 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт барих Баянхошууны хөрсний ус, гадаргын ус зайлуулах шугам сүлжээний ажлын хүрээнд нийт 182 нэгж талбар өртсөнөөс гүйцэтгэгч байгууллагатай зураг төсөл дээр зөвшилцөж, хээрийн болон суурин судалгаа хийж 106 нэгж талбарыг чөлөөлөхөөр зөвшилцөж, 76 айл өрхийг нөлөөллөөс гаргасан. 40 нэгж талбарын байршлыг 26, 34 дүгээр хороо Баянголын аманд шилжүүлсэн. 2024, 2025 онд 52 иргэний өмчилж, эзэмшиж буй газар болон үл хөдлөх хөрөнгийг 4.2 тэрбум төгрөгийн нөхөх олговрын захирамж гарсан. 14 айл өрхийн хашааг нөхөх олговоргүйгээр татуулсан. Дүүргийн 40, 41 дүгээр хороодын нутаг дэвсгэрт Риотинто төслийн санхүүжилтээр хийгдэх Цэцэрлэгт хүрээлэн байгуулах 21 га газрын 61 нэгж талбараас 15 нэгж талбарын эзэмшигч, өмчлөгчтэй байршил шилжүүлэхээр зөвшилцсөн. 2025 онд 17 удаагийн дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 161 нэгж талбарын 72,776 м2 талбайг 18.5 тэрбум төгрөгийн нөхөх олговортойгоор чөлөөлсөн. Авто замын нөлөөлөлд өртсөн 23 иргэний 1163 м2 талбайг 224.1 сая төгрөгийн нөхөх олговор олгож чөлөөлсөн.	25.0

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Дүүргийн хүн амын эрүүл мэндийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлнэ.

22	2.1.1.Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр ханган, барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.	Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх орчин, барилга байгууламжийг сайжруулах ажлын хүрээнд 2025 онд дүүргийн хэмжээнд 2 шинэ барилга, 2 барилгын их засварын ажил хийгдэж байна. Азийн хөгжлийн банк, орон нутгийн төсвийн дэмжлэгтэйгээр "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд 26 дугаар хороонд "Жишиг өрхийн эрүүл мэндийн төв" барих, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Эрүүл үрс" хүүхдийн сэргээн засах төвүүд баригдаж, барилгын ажил 80 хувьтай үргэлжилж, 2026 оны 1 дүгээр улирлад багтаан хүлээлгэж өгөхөөр байна. Нэгдсэн эмнэлгийн хуучин барилгыг 2.1 тэрбум, Эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг 4.4 тэрбум төгрөгөөр хийх тендерүүд шалгарч, ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах, орчин үеийн дэвшилтэт технологиор дэмжих ажлын хүрээнд орон нутгийн төсвөөр "Эрүүл мэндийн төв"-д хүчилтөрөгчийн үйлдвэр барих ажлыг хийж дуусгалаа. China General Technology группээс эмнэлгийн салбарын солилцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай рентген аппаратыг олгохоор шийдвэрлэсэн. Нэгдсэн эмнэлгийн харьяа 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах хүүхдийн амбулаторийн барилгын гадна дэд бүтцийн ажил, 1.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлууд хийгдэж байна.	25.0
23	2.1.2.Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулан, Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах, эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг "Нийгмийн эрүүл мэндийн бодлого", "Үйлчлүүлэгчтэй харилцах арга, харилцааны ур чадвар", "Бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх нь" зэрэг сэдвээр 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 105 ажилтныг хамруулж, чадавхжууллаа. 2025 онд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвүүдтэй хамтран "Нийгмийн эрүүл мэнд ба өвчлөл", "Өвчлөл эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлс" судалгааг зохион байгуулж 487 иргэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтныг хамруулан, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн "Нас баралтын шалтгаан нөхцөлийн судалгаа"-г 1 удаа хийж, дүгнэлтийг танилцуулсан. Дүгнэлт, санал хүсэлтийг дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй эрүүл мэндийн төслүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн Б корпусд "Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийг байгуулахаар санал, төсөл боловсруулаад байна.	20.0

24	2.1.3.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг эрчимжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, өвчлөл, эндэгдлийг бууруулна.	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 27, 28, 29 дүгээр тогтоолуудаар “Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих” 3 төслийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн цахим сургалтыг 506, танхимын сургалтыг 705 удаа зохион байгуулж, 119,134 иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, ахмад настан, хүүхэд, байгууллагын албан хаагчид гэх 5 ангилалд 458 удаа зохион байгуулж 63,683 иргэнийг хамруулан 19,480 өвчлөлийг эрт илрүүлээ. Өвчтэй илэрсэн 13,360 иргэнийг эрүүлжүүлж, дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагын хяналтад 6120 иргэнийг илгээсэн. Эрүүлжилт 68 хувьтай байна. Төслүүдийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран “Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар орон нутаг түшиглэн жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь”, “Архины шалтгаант эмгэгийн илрүүлэг ба тусламж, үйлчилгээний уялдаа”, “Өөрчлөлтийг өөрөөсөө” сургалт, “Хариуцлагатай сонголт” аян, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийн өргөтгөсөн хурлуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 581 эрүүл мэндийн ажилтныг хамруулсан.	25.0
25	2.1.4.Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч мэргэжилтнүүдийг нарийн мэргэжлээр сургах, чадавхжуулах ажлын хүрээнд 15 удирдах ажилтан, 37 эмч, 7 сувилагч, нийт 59 эмч, мэргэжилтэн нарийн мэргэжлээр буюу дотор, хүүхэд, өрх, хөнгөвчлөх, яаралтай тусламжийн чиглэлээр суралцаж байна. Сургалтад хамрагдаж байгаа нийт эмч, мэргэжилтний 6 хүн төрийн сангийн тэтгэлэгээр, 26 хүн байгууллагын төсвөөс, 27 хүн өөрийн зардлаар суралцаж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”, “Нотолгоонд суурилсан сувилахуй” байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалтаар 86 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулж кредит олгож, 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотод зохион байгуулагдсан Олон улсын “Wonca-2025” Ази номхон далайн бүсийн хуралд өрхийн эрүүл мэндийн төвөөс 3, дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 1 ажилтан хамрагдаж, 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Дүүргийн Эрүүл мэндийн төв 6, Нэгдсэн эмнэлэг 6 ажилтны нийгмийн баталгааг хангаж орон сууцны урьдчилгаа төлбөрийн 240.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	25.0
26	2.1.5.Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, яаралтай тусламж үзүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ.	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, ижил төстэй гадаад, дотоодын байгууллагын туршлага судлах арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 239 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Япон Улсын Изүнокүни хот, Сонгинохайрхан дүүрэг хоорондын хамтын ажиллагааны 10 жилийн ойн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвийн 26, Эрүүл мэндийн төвийн 1, нийт 27 эмчийг	25.0

		<p>туршлага судлах арга хэмжээнд хамруулж, Изү эрүүл мэндийн төв, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа, сувилгааны төв, Шизүока мужийн Их сургуулийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцууллаа. “Батцэцэн” өрхийн эрүүл мэндийн төвд туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, “Цаг олголт”, “Угтах үйлчилгээ”, “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-тэй танилцаж, туршлага судаллаа. Анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээг чанаржуулах зорилгоор “Яаралтай тусламжийн нийгэмлэг”-тэй хамтран 75 эмч, 56 сувилагчийг ажлын байранд сурган, чадавхжуулж, 11 өрхийн эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн цүнхтэй багцыг олголоо. Япон улсын Изүнокүни хотоос тусгай зориулалтын автомашиныг “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр хүлээн авч, Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өглөө.</p>	
27	<p>2.1.6.Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>Халдварт өвчнөөс сэргийлэх ажлын хүрээнд улаан бурхан өвчний нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 33,073 хүүхдээс 27,640 хүүхэд, Папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 11 настай 8300 хүүхдээс 3106 хүүхдийг хамруулж, давхардсан тоогоор 36 сургуульд 70 удаагийн сургалтаар 195 эмч, 631 эцэг, эхчүүдэд мэдээлэл хүргэсэн. “Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд олон нийтээр удирдуулсан хяналтын тогтолцоо бий болгох” төсөлд дэмжлэг үзүүлэх “Орон нутгийн салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг баталж тайлант хугацаанд 6 удаа хуралдаж, 7 асуудлыг хэлэлцэн, судалгааны дүгнэлтийг хийгээд байна. “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, 150 иргэнийг рентген үзлэгт хамруулж, мэдээлэл зөвлөгөө өгч, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй 124,780 хүнд “Амьсгалын замын халдвараас сэргийлэх”, “Гарын ариун цэвэр сахих арга”, “Амны хаалтыг зөв хэрэглэх”, “Дархлаагаа хэрхэн дэмжих вэ” зэрэг сэдвүүдээр сургалт явуулан, цахим хуудсанд 18 төрлийн постер, 11 төрлийн сурталчилгааны материал, 5 видео хичээлийг байршуулж 187,810 иргэнд мэдээлэл хүргэсэн. Нийт 29 хүүхдийн байгууллагад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 11,507 хүүхэд, 215 багш ажилчдыг хамруулж, 452 эцэг, эхэд халдвараас хэрхэн сэргийлэх талаар сургалтыг зохион байгуулж, 2450 ширхэг тараах материал тараалаа. Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг, шинэ эмчилгээний арга зүйн 2 удаагийн сургалтад 31 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг, 28 удаагийн сургалтад 2616 иргэн, 65 байгууллагын 99 эмч, эмнэлгийн мэргэжилтэнийг хамруулсан. Томуугийн дархлаажуулалтад хүүхэд 16,723, ахмад 7234, жирэмсэн буюу ХБИ 8265, нийт 32,222 хүн амыг хамруулсан. Томуугийн дэгдэлттэй холбоотойгоор Баянхошуу амбулаторид 50 ортой хүүхдийн тасгийг нэмэлтээр ажиллуулж дүүргийн Засаг даргын Тамгын газраас 36.0 сая төгрөгийн, Нэгдсэн эмнэлэгт 30.3 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн.</p>	25.0

2.2.Орон нутгийн онцлогт нийцсэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг үргэлжлүүлнэ.			
28	2.2.1.“Хүн амын чанартай, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төсөл”-ийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 33 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөг, арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 790 ажил хайгч иргэн, 17 ажил олгогч байгууллагыг оролцуулан, 300 гаруй ажлын байрны захиалгын дагуу 85 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучиллаа. “Ажилтай, орлоготой залуус” арга хэмжээний хүрээнд “Нарийн боов, тогооч, нярав” мэргэжлээр суралцсан 43 залууст чадамжийн гэрчилгээ гардуулж ажлын байранд зуучиллаа. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-үүдийн түрээсийн, ашиглалтын зардалд нийт 63.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-т нийт 21 хорооны 716 өрхийг мэргэжлийн сургалтуудад хамруулан 303 иргэнийг чадамжийн гэрчилгээтэй болгоод байна. Бичил бизнес эрхлэгч 386 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад, 35 иргэнийг туршлага судлах арга хэмжээнд, захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх 18 удаагийн сургалтад 365 иргэн, 786 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулж чадавхжууллаа. “АЖИЛ ОЛГОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН-2025” арга хэмжээг зохион байгуулж нийт 700 гаруй ажил олгогч оролцож харилцан туршлага солилцлоо.	25.0
29	2.2.2.Шинээр байгуулагдах хотуудын онцлогт нийцсэн худалдаа үйлчилгээний борлуулалтын цэгийг төрөлжүүлэн бий болгож, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, зорилтот бүлэгт чиглэсэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэл, мэдээлэл сургалтын төвд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, худалдан борлуулах үйлчилгээний борлуулалтын цэгийг нээх 200,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлснээр 3 байршилд шинэ цэгүүдийг нээж үйл ажиллагааг өргөжүүлж байна. Дүүргийн 29 дүгээр хороонд байрлах “Шинэ Драгон терминал” төвийн В1 давхарт 48 м2 талбайд 7 иргэн, 1 дүгээр давхарт 35 м2 талбайд 15 иргэни, Соёолж худалдааны төвийн 6 давхарт 28 м2 талбайд 6 үйлдвэр эрхлэгчийг хамруулан, байнгын борлуулалтын цэгийг 3 байршилд шинээр бий болгож, нийт 28 иргэнд дэмжлэг үзүүллээ. Дүүргийн хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор нийт 7 удаагийн үзэсгэлэн худалдаанд 162 үйлдвэр эрхлэгчийг хамруулж 553.1 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.	20.0
30	2.2.3.Төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус олон улсын байгууллагыг түшиглэн хэрэгжүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг үргэлжлүүлнэ.	Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Монголын Улаан загалмайн нийгэмлэгээс хэрэгжүүлсэн “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-т зорилтот бүлгийн 716 өрхийг хамруулж, 303 өрх үйлдвэрлэл эрхэлж байна. Эдгээр өрхүүдийг бизнесээ хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ брэнджүүлэх сургалтад хамруулан, ажлын байраар хангаж, чиглүүлэгчдийг зөвлөх үйлчилгээний төсөлд хамруулан дэмжлэг үзүүлж	20.0

		байна. Гэр бүлийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Нээлттэй өдөрлөг”-т “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрт хамрагдсан 60 иргэний бүтээгдэхүүнийг үзэсгэлэн, худалдаанд оролцуулж, борлуулалтын дэмжлэг үзүүлсэн. “Холт” олон улсын байгууллага нь амьжиргааны түвшин доогуур хөгжлийн бэрхшээлтэй 260 хүүхдэд 55.3 сая төгрөг, 4 өрхөд иж бүрэн гэрийн дэмжлэг, “Эрдэм өргөө” номын санг байгуулж, 9, 12, 62, 65, 143 дугаар сургуулиудын 1-12 ангийн сурагчдад ном унших, хичээл хийх, интернет ашиглах үйлчилгээг үзүүлж байна. Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын “Монголчууд монголчууддаа” хөтөлбөрийн хүрээнд өөрийн гэсэн орон гэргүй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настантай 10 өрхөд иж бүрэн 5 ханатай гэр олголоо.	
31	2.2.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг түгээх, шинээр ашиглалтад орж буй барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хотын стандартад нийцүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэн, асран хамгаалагчдын эрүүл мэндийн дэмжих үзлэг”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үзлэг” өдөрлөгүүдийг зохион байгуулж, 6 төрлийн шинжилгээ, 8 нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт нийт 200 асран хамгаалагч, 350 хүүхдийг хамруулж, хоёрдогч өвчлөлөөс сэргийллээ. Дүүргийн 43 хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Спортын нөхөрсөг тэмцээн”-ийг зохион байгуулж, нийт 60 гаруй иргэдийг хамруулсан. Монголын Хүүхдийн Спортын VIII Их Наадмын хүрээнд Өсвөр үеийн “Пара хонхот бөмбөг”-ийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулан 6 эмэгтэй 6 эрэгтэй нийт 12 багийн 60 тамирчин, “Пара бочи” тэмцээнд хөгжлийн бэрхшээлтэй 50 хүүхдийг хамруулж, спортоор дамжуулан нийгмийн оролцоог дэмжин ажилласан. Монгол Улсын Их Хурлын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дэмжих” бүлэгтэй хамтран “ИРГЭДТЭЙ САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ”-ыг 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв нь Мягмар, Лхагва, Баасан гаригуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал хийж, бусад өдрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг тогтмол үзүүлж байна. Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, асран хамгаалагч 19 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, 107 иргэнд хууль эрх зүйн сургалт явуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан стандартад нийцсэн налуу шатыг 6 байгууллагад хийж, 1547м явган замд хөтөч, 13 авто зогсоолд тэмдэг, тэмдэглэгээ хийлээ.	20.0
32	2.2.5.Ахмадын хөгжлийн төвүүдийг байгуулан, ”Ахмад настны хөгжлийг дэмжих” төсөл хэрэгжүүлнэ.	“Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл”-ийг 2025-2028 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 31 дүгээр тогтоолоор батлуулан, 2025 оны төлөвлөгөөг 3 зорилт, 18 арга хэмжээтэйгээр төлөвлөн, хэрэгжүүлж байна. Цагаан сар-Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, нийт 2458 ахмад настныг	25.0

		<p>хамрууллаа. Дүүргийн ахмадын хөгжлийн төв, хороодын ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төвүүдийн үйл ажиллагааг хөгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлж ахмад настанд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн багийг байгуулан хороодод чиглэл хүргүүллээ. Хороо тус бүрд “Орон тооны бус ажлын хэсэг”-ийг байгуулан ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, нийгмийн харилцааны идэвх, оролцоог нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор хороодод “Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийг бий болгохоор ажиллаж байна. Ахмад настнуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний хөгжил, оролцоог дэмжих зорилгоор ахмадын спортын “Долдугаар наадам”-ын эхний шатны тэмцээнийг зохион байгууллаа. “Ахмадын туршлага байгууллагын хөгжилд” ахмад настны талаарх хууль тогтоомж таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах, хандлагыг дээшлүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлагууд, 43 хорооны Засаг дарга нар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар, аж ахуй нэгж байгууллагын удирдлагууд, хороодын ахмадын зөвлөлийн дарга нар нийт 300 гаруй удирдлагуудыг хамрууллаа.</p>	
33	<p>2.2.6.Иргэдийн нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Сайн дурын даатгалд нийт 1359 иргэн шинээр хамрагдсан байна. Үүнээс шинээр малчин даатгуулагч-21, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх-11, 0-3 насны хүүхдээ асарч буй эх-112, энгийн даатгуулагч-1215 даатгуулагч даатгуулсан байна. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвтэй хамтран богино хэмжээний 8 REEL бэлтгэн, дүүргийн цахим хаяг, 43 хорооны цахим хуудас, группд, Нийгмийн даатгалын газрын пэйж хуудсандаа түгээн ажилласан. Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар пэйж хуудсанд 4 reel, 11 постер мэдээлэл бэлтгэн 43 хорооны группт шейр хийн түгээсэн. НДЕГ-ын оруулсан богино хэмжээний 26 REEL мэдээллийг цахим орчинд түгээж 173,230 иргэнд мэдээлэл хүргээд байна. Хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөгөөр 68 иргэнд сайн дурын даатгалын талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэсэн. Нийгмийн хамгааллын тусгай төвөөр үйлчлүүлж буй 67 иргэн, ОБЕГ-ын дэргэдэх 179 дүгээр ангийн 18 албан хаагчдад, Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн 28 албан хаагчдад, Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ 16 албан хаагчдад, “Хос эрдэмт үйлс” ХХК-ий 4 ажилчдад, Аж ахуй нэгж байгуулах хүсэл сонирхолтой 25 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг томоохон 25 аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагууд болон холбогдох алба хэлтсийн мэргэжилтнүүд, нийт 183 албан журмын даатгуулагчид, Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулах сургалт, мэдээлэл хүргэн ажиллалаа.</p>	25.0

2.3.Багш, суралцагчийн хөгжлийг дэмжин чадавхжуулж, хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй хүргэн, сургалтын байгууллагын орчныг сайжруулна.			
34	2.3.1.Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлж, сургуулийн ээлж, цэцэрлэгийн анги дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.	Дүүргийн хэмжээнд 2 сургууль, 2 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 4 цэцэрлэг, 1 цэцэрлэгийн өргөтгөл шинээр баригдаж бүрэн ашиглалтад орсон ба 4 сургууль 70-90 хувьтай, 4 сургуулийн өргөтгөл 30-90 хувьтай, 2 цэцэрлэгийн барилга 30 хүртэл хувьтай, 2 цэцэрлэгийн барилга 80 хувьтай, 5 цэцэрлэгийн барилга 90-100 хувьтай үргэлжилж байна. 2025 онд 1 цэцэрлэгийн барилга, 1 сургуулийн өргөтгөл ашиглалтад орохоор байна. Ингэснээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орны тоо 2435-аар, сургуулийн суудлын тоо 4960-аар нэмэгдэж, хүртээмж сайжирч, анги дүүргэлт стандартын төвшинд хүрнэ. Дүүргийн 20, 27, 30, 31, 32, 42 дугаар хороодод баригдаж байгаа сургуулийн барилга 5-89 хувьтай, түр зогссон байдалтай, 23, 27, 29, 33, 42 дугаар хорооны цэцэрлэгийн барилга 30-90 хувийн гүйцэтгэлтэй, 40 дүгээр хорооны 240 ортой цэцэрлэгийн барилга 15 хувь, 76 дугаар сургуулийн 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилга 90 хувьтай түр зогссон, “Ирээдүй сургуулийн 320 хүүхдийн суудалтай давхарын өргөтгөл 30 хувийн гүйцэтгэлтэй байна. 23 дугаар хороонд 75 ортой 285 дугаар цэцэрлэгийн салбар цэцэрлэгийн барилгыг орон нутгийн хөрөнгөөр, анх удаа санхүүгийн түрээсээр 153 дугаар сургуулийн салбар 320 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга худалдан авч үйл ажиллагааг эхлүүлсэн. 7, 8, 21, 26, 32, 33 дүгээр хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлууд 10-95 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/186 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар 5 сургууль, 7 цэцэрлэгт 1.8 тэрбум төгрөгийн засвар үйлчилгээ үзүүлэхээр 5 багц бүхий ажлын тендер зарлагдсан боловч төсөв татагдсан тул хэрэгжээгүй болно.	25.0
35	2.3.2.Багшийн хөгжлийг дэмжих, гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулж, тогтвортой ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Багшийн хөгжлийг дэмжих, гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих бүлгээс зохион байгуулсан 52 үзүүлэх ажилд 112 цэцэрлэгийн 1200 багш, 5 чиглэлийн сургалтад 70 эрхлэгч, 88 арга зүйч, 800 багшийг, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг сайжруулах, удирдах ажилтны удирдан зохион байгуулах, манлайлах, хувь хүний хөгжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага хуримтлуулах, чадваржуулах 2 өдрийн сургалтад төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын 67 байгууллагын эрхлэгч, арга зүйч 150 багш, нийт 2308 хүнийг хамрууллаа. ОХУ-ын Герцений Улсын багшийн Их сургуультай хамтран багш нарын орос хэлний мэдлэгийг дээшлүүлэх 45 хоногийн сургалтыг зохион байгуулж, А2 түвшний сургалтад 49 багш, А1 түвшний сургалтад 11 багшийг хамруулж, төгсгөөд байна. “Бүтээлч багш-2025” туршлага солилцох арга хэмжээг төрийн өмчийн 71	20.0

		цэцэрлэгийн дунд 2 үе шаттай зохион байгуулж, 2 дугаар шатанд шалгарсан 80 багшийг бүтээлийн үзэсгэлэн гаргаж, “Бүтээлч багш”-аар өргөмжилж, 7 байгууллагыг шалгаруулсан. Ерөнхий боловсролын 151 дүгээр сургуулийн олон улсын Кембрижийн хөтөлбөрийн жилийн хураамж 15.6 сая төгрөгийг шийдвэрлэн 2025 оны сургалтын эрх авч, 3 багш сургалтад хамрагдсан. Боловсрол соёл, эрх зүйн дээд сургуультай хамтран боловсрол судлалын магистрт 12 багш, сургуулийн өмнөх боловсролын багшаар 6 багшийг Засгийн газрын тэтгэлэгээр, Монгол-Солонголын политехникийн коллежийн “Цахилгаанчин” мэргэжлийн 1 жилийн сургалтад сургууль, цэцэрлэгийн 45 цахилгаанчинг төлбөрийн хөнгөлттэй нөхцөлөөр суралцуулж, 5 багшид 3.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.	
36	2.3.3.Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны орц найрлага, аюулгүй байдлыг хангуулах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг нэмэлтээр олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Ерөнхий боловсролын 143, 151 дүгээр сургуулиудад “Сүү” зорилтот төслийг хэрэгжүүлж, шаардагдах 77.5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн 2050 суралцагч хөтөлбөрт хамрагдаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 12 сургуульд “Сургуулийн өөрийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ”-г хэрэгжүүлж байгаа бөгөөд үлдсэн сургуулиудад өөрийн гал тогоог ажиллуулахаар төлөвлөсөн. Мөн 9, 123 дугаар сургуулиудад “Койка” ОУБ-аас хүүхдийн хоолны гал тогоог тохижуулах төслийг хэрэгжүүлж байна. “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хоол, шим тэжээлийн онцлог”, “Шилдэг тогооч-2025” туршлага солилцох сургалт, арга хэмжээг төрийн өмчийн 71 цэцэрлэгийн дунд зохион байгуулж, 200 гаруй тогооч, хоол зүйчдийг оролцуулж, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн, 14 тогоочийг шилдгээр шалгарууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хооллох зөв дадал, соёл, тэнцвэртэй хооллолтын ач холбогдлын таниулах “Өглөөний цай тогтмол ууж хэвшье” сургалтыг явуулж эхэлсэн бөгөөд 9, 143, 153, 151 дүгээр сургуулиудын 278 суралцагч, 78 эцэг, эх, асран хамгаалагч хамрагдсан.	25.0
37	2.3.4.Хүүхдэд суурь дадал хэвшил, бие даан суралцах чадавх эзэмшүүлэх, хүүхдийн хөгжил, хамгаалал, сургалтын чанарыг дээшлүүлэн мэргэжил сонголтыг оновчтой болгох “Боловсрол” төслийг хэрэгжүүлнэ.	“Боловсрол” төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 34 дүгээр тогтоолоор батлуулж, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, багш нарыг мэдлэг ур чадварыг ахиулах “Амжилтын алхам” богино хугацааны төслийг хэрэгжүүлж, математикийн хичээлээр 14 удаагийн 49 цагийн сургалт, 7 удаагийн лайв хичээл, 1 удаагийн сорил, нийгэм судлалын хичээлээр 22 удаагийн 66 цагийн сургалт, 8 удаагийн лайв хичээл, 3 удаагийн сорил авч, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэн математикт 1570 сурагч, 117 багш, нийгэм судлалд 7852 сурагч, 30 багш, англи хэлний сургалтад 34 багш хамрагдсан. “Сонгинохайрхан Боловсрол-2025” арга хэмжээг зохион байгуулж, 10-12 ангийн нийт 1000 гаруй сурагчдад их, дээд сургууль, боловсрол сургалтын төвүүдийн элсэлт, тэтгэлэгт хөтөлбөрт	25.0

		хамрагдах талаар мэдээлэл хүргэн, сурлага, урлаг, спорт төрөлд амжилт гаргасан 30 сурагчийн шагнаж урамшууллаа. 12 дугаар ангийн 760 сурагчдад “Мэргэжил сонголт”, “Хувь хүний хөгжил” сэдвээр илтгэл танилцууллаа. “Чадварлаг багш, шавь-2025” арга зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн 31 сургууль, 114 цэцэрлэгийн 700 гаруй багш хамрагдан, ЭЕШ-д 800 оноо авсан 18 төгсөгч, 6 ерөнхий боловсролын сургууль, 17 сургуулийн өмнөх боловсролын шилдэг байгууллага, 114 багшийг шалгаруулж урамшуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын гадаад хэлний мэдлэг, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, олон улсын туршлага судлах зорилгоор Филиппин улсын 6 академи, ерөнхий боловсролын 6 сургууль хамтран ажиллах санамж бичиг байгуулж, эхний ээлжийн 8 багшийг 12 дугаар сард 1 сарын сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн.	
38	2.3.5.Ерөнхий боловсролын сургуульд төрөлжсөн болон олон улсын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Олон Улсын “Кембриж”-ийн хөтөлбөртэй 151 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн 3 бүлэгт 90 сурагч 7 дугаар ангийн 3 бүлэгт 89 сурагч нийт 179 сурагч Математик, Англи хэл, Хими, Биологи, Физик, Мэдээллийн технологи хичээлүүдийг Кембрижийн олон улсын хөтөлбөрөөр судалж байна. “Кембриж”-ийн их сургуулийн цахим сургалтад англи хэлний 4, математикийн 1 багш, олон улсын хөтөлбөр хариуцсан сургалтын менежер 1, нийт 6 багш хамрагдсан ба “Кембриж”-ийн хөтөлбөрийн 1128 ширхэг сурах бичгийг захиалан авч ашиглаж байна. Герман улсын SES олон улсын байгууллагаар дамжуулан доктор профессор Хорст Тонн багшийг урьж, ажиллуулж байна. Олон улсын хөтөлбөрийн анхны мөк 1 шалгалтыг амжилттай зохион байгуулсан. Монгол-Оросын хамтарсан 162 дугаар сургуулийн 1-2 дугаар ангийн 306 суралцагчдын үдийн хоолны зардал, /40.9 сая төгрөг/ 2 улсын гэрээний дагуу ОХУ-ын 15 багшийн амьдрах орон сууцны түрээс, тохижилт, ашиглалтын зардал 257.6 сая төгрөгийг шийдвэрлэж, 12 багшийн амьдрах орон сууцыг түрээслэсэн. Цаашид сургуулийн өргөтгөл, багш ажилчдын орон сууц, усан бассейн, спорт комплекс барихаар төлөвлөөд байна. Нэгдүгээр сургуулийн математикийн хөтөлбөрөөр 65 дугаар сургуулийн 2 анги хичээллэж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад БШУСайдын А/262 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу төрөлжсөн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг магадлан нягтлах ажлыг 42, 67, Ирээдүй сургуулиудад зохион байгуулж, хөтөлбөр, төлөвлөгөө, орчин нөхцөлд магадлан баталгаажуулсан.	25.0
39	2.3.6.Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан сургалтын үйл ажиллагааг дэмжинэ.	Тусгай хэрэгцээт хүүхдийн 341 дүгээр цэцэрлэг ашиглалтад орсонтой холбогдуулан ажиллах хүний нөөцийг бэлтгэх ажлыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-тэй хамтран зохион байгууллаа. Сургалтад цэцэрлэгийн 30 багш, эмч, ажилтнууд хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд онол, дадлага хослуулан суралцсан. Цэцэрлэгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд	20.0

		40.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах “Боловсрол хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллаа. Зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, хөгжих, сурах эрхийг хангах зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн “Дэмжлэгийн баг”-ийг чадавхжуулах сургалтыг Монгол Улсын Боловсролын их сургууль, “Илтгэх индрийн ирээдүй” ТББ, “Гэрэлт андаган” ТББ-тай хамтран 2 удаа зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 617 гишүүнийг хамруулж, чадавхжуулсан. “Боловсрол хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлыг 2 удаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийг ерөнхий боловсруулан сургуульд хамруулаад байна. 2025 онд ерөнхий боловсролын сургууль 376 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамран сургах зарчмаар суралцаж байна.	
40	2.3.7.Насан туршийн суралцахуйн төвийн материаллаг бааз, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль завсардалтыг бууруулан, иргэдэд амьдрах ухааны олон талт сургалтыг зохион байгуулна.	Сургууль завсардалтыг бууруулах ажлын хүрээнд боловсрол нөхөн олгох сургалтад дараах байдлаар хамрагдаж байна. Ангилбал: <ul style="list-style-type: none"> - Бага боловсролд 18, - Суурь боловсролд 26, - Бүрэн дунд боловсролд 43, - Бичиг үсгийн анхан шатны боловсролд 5 иргэн тус тус хамрагдан суралцаж байна. Иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэхээр иргэдийн хэрэгцээнд тулгуурлан боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх үндсэн 6 чиглэлээр /Амьдрах ухаан, суртахуун төлөвшил, Гоо зүй, Гэр бүл, Шинжлэх ухаан, Иргэний боловсрол/ 35 удаагийн сургалтыг 727 иргэнд, 24 нөлөөллийн ажлыг 621 иргэнд тус тус зохион байгуулсан. Насан туршийн суралцахуйн төвийн материаллаг бааз, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын тоног төхөөрөмжийн 19.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	25.0
2.4.Олон нийтэд чиглэсэн нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг нэмэгдүүлэн, биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.			
41	2.4.1.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх 2 үндсэн чиглэлийн хүрээнд нийт 53 арга хэмжээ зохион байгуулж, 2,836 байгууллагын 35,617 өсвөр үе, залуучууд, ахмад настан, иргэдийг хамрууллаа. Үүнд нийтийн биеийн тамирын чиглэлээр 25 арга хэмжээ зохион байгуулж, 942 байгууллагын 25,825 иргэд, албан хаагчдыг, спортын уралдаан, тэмцээний чиглэлээр 28 арга хэмжээг явуулж 1894 байгууллагын 9792 өсвөрийн тамирчин сурагчид, насанд хүрэгчдийг хамрууллаа. Хувийн хэвшлийн биеийн тамир, спортын байгууллага, холбоотой хамтран 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. “Шугаман бүжгийн холбоо”, “Сүү” ХК-тай хамтран “Эрүүл-	25.0

		Монгол хүн” аяны хүрээнд өглөөний дасгал арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 360 ахмад настныг, “Гэгээн өргөө” НҮТББ-тай хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтнуудын дунд гар бөмбөг, сагсан бөмбөг 3х3, боулинг, байт харваа, хийн буудлага зэрэг 6 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 29 сургуулийн 96 менежер, 49 нийгмийн ажилтныг хамруулан зохион байгуулсан. Үндэсний өв, соёлыг сэргээн хөгжүүлэх, иргэдийн дунд үндэсний уламжлалт спортыг сурталчлан таниулах 2 арга хэмжээг “Монгол бөхийн холбоо”, “Мөсөн шагайн холбоо”-той хамтран (аймаг, цэргийн цолтой 64 бөхийн барилдаан, мөсөн шагайн харваа) зохион байгууллаа. Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборт “Кидс спортс” ХХК-тай хамтран хөл бөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах “Fanat cup” “TG cup” тэмцээнүүдийг 9-11 насны ангиллалаар зохион байгуулж 80 багийн 1100 гаруй тамирчин сурагчдыг хамрууллаа.	
42	2.4.2.Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тамирчдын ур чадварыг дээшлүүлэн, олон улсын чанартай уралдаан, тэмцээнүүдэд оролцоход дэмжлэг үзүүлнэ.	Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 18 төрлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрлөөр нэмэгдүүлэн 19 төрлөөр хичээллүүлж байна. 2025 онд өсвөрийн шигшээ багийн тамирчид 95 алт, 76 мөнгө, 118 хүрэл, нийт 356 медаль хүртсэн амжилтыг гаргасан. Олон улсын чанартай тэмцээн, уралдаанд оролцсон 14 тамирчинд 14.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Хүүхдийн спортын VIII наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 5х5 сагсан бөмбөг, чөлөөт бөх, даам, гар бөмбөг, ширээний теннис, бокс, жудо бөх зэрэг 23 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 409 байгууллагын нийт 7783 өсвөрийн тамирчдыг хамруулан, шалгарсан 322 тамирчин шигшээ тэмцээнд оролцож 15 алт, 24 мөнгө, 38 хүрэл, нийт 77 медаль хүртсэн амжилтыг үзүүлээд байна.	25.0
43	2.4.3.Өвлийн спортын ордон, усан спорт сургалтын төв, хөл бөмбөгийн талбай бүхий спорт цогцолборуудыг ашиглалтад оруулна.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 42 дугаар тогтоолоор 3 дугаар хороонд ашиглалтад орсон хөл бөмбөгийн талбай бүхий спорт цогцолбор, 34 дүгээр хороонд ашиглалтад орох усан спорт сургалтын төвийг “Усан спорт сургалтын төв” УТҮГ-т харьяалуулж, “Спорт цогцолбор” УТҮГ болгон нэрийг өөрчилсөн. Хөл бөмбөгийн талбай бүхий спорт цогцолборыг 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр нээж, хүлээн авч, үйл ажиллагааг эхлүүллээ. Усан спорт, сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжих, тус спортоор хичээллэх хүүхэд, залуучуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагын 60 албан хаагчийг 30 хувийн хөнгөлөлтэй үнээр сургалтад хамруулж байна. Тайлант хугацаанд бассейнд 85 иргэн, 725 хүүхэд, 370 хүн 1 цагийн сэлэлт, фитнес 190, спиннингд 112, лабораториор 1090, нийт давхардсан тоогоор 2572 гаруй иргэн үйлчлүүлсэн. Улсын төсвийн 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 34 дүгээр хороонд 25 метрийн урттай таван зам бүхий усан бассейн, боулинг, фитнесийн тоног төхөөрөмжтэй олон улсын	70.0

		стандартад нийцсэн “Усан спорт сургалтын төв”-ийн барилга угсралтын ажлын явц 95 хувьтай, цэвэр ус холбогдоогүй тул улсын комисс ажиллаагүй хүлээгдэж байна. Улсын төсвийн 18.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 20 дугаар хороонд “Өвлийн спортын ордон” барих ажлын тендерт “Тотал идеал” ХХК шалгарсан ба барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна.	
2.5.Иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлэн, соёл, урлагийн үйл ажиллагааг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, түүх, соёлын дурсгал, өвийг хадгалж, хамгаалах, илрүүлэх, өвлүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.			
44	2.5.1.Шинээр байгуулагдах хотуудад соёлын орон зай бүхий соёл, урлагийн олон төрөлт үйлчилгээтэй төвүүдийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хөгжлийн төв”-ийн барилга 90 хувийн гүйцэтгэлтэй байна.	05.0
45	2.5.2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, соёл амралт, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын дурсгалт газрууд болох 14 хөшөө дурсгалд засвар, шинэчлэлтийн ажлыг дэд бүтцийн хөгжлийн албатай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажил хангаад байна. Мөн 16 булш, хиргисүүр, 185 дурсгалын судалгаа мэдээллийг шинэчлэн, кадастржуулж, газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны Археологийн хүрээлэн, Газар зохион байгуулалтын албаны мэргэжлийн багтай хамтран хэрэгжүүлсэн.	20.0
46	2.5.3.Уламжлалт өв соёл, зан заншлаа сурталчлан таниулах, биет болон биет бус өвийг илрүүлэх, өвлүүлэх, алдаршуулах ажлыг зохион байгуулна.	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын дунд “Өвлөө, дээдэлье, бахархъя” уриан дор “Үл тасрах өв” зөвлөгөөн, “Өвийн Уянга” өвлөн уламжлагчдын анхдугаар уралдааныг зохион байгуулж, шилдгүүдийн “Гала” тоглолтыг Улсын Хүүхэд, Залуучуудын театрт зохион байгуулж, давхардсан тоогоор 460 гаруй өвлөн уламжлагчдыг хамруулсан. Нийслэлийн “Иргэдийн баяр”, “Даншиг наадам-Хүрээ цам”-д өвлөн уламжлагч иргэдийг хамруулан, соёлын гэр болон бөмбөгөр театрт урлагийн тоглолтыг давхардсан тоогоор 5,689 иргэнд хүргэсэн. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн анхан шатны шалгаруулалтыг 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, шалгарсан 13 өвлөн уламжлагч “Нүүдэлчин” дэлхийн фестивальд оролцсон ба 3 иргэн шилдэг өвлөн уламжлагчийн шагнал хүртсэн амжилтийг үзүүлээд байна. “Нүүдэлчин дэлхийн соёл”-ын фестивалийн анхан шатны шалгаруулалтын шилдэг дүүргээр шалгарлаа.	25.0
47	2.5.4.“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2”-ыг боловсруулан хэрэгжүүлнэ.	“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх” төсөл-2 боловсруулан хэлэлцүүлж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 30 дугаар тогтоолоор батлуулан, төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. “Хотын соёл–Хамтын хариуцлага” нөлөөллийн ажлыг “Хотын соёлыг Хамтаар	25.0

		<p>бүтээе!" уриан дор, "Соёл түгээе" уриан дор "Соёлтой Сонгинохайрханчууд-4" аяныг тус тус зохион байгуулан, өмчийн хэлбэр харгалзахгүй нийт 333 байгууллага, аж ахуйн нэгжүүдийг оролцуулж 215,315 албан хаагч, иргэдийг хамруулаад байна. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын дунд "Үл тасрах өв" зөвлөгөөн, "Өвийн Уянга" урлагийн наадмыг зохион байгуулж 1800 гаруй хүүхэд, иргэнийг хамруулсан. Дүүргийн 20 өвлөн уламжлагчдын бүтээлээр рийл контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүтээж, цахим орчинд иргэд олон нийтэд сурталчлан, таниулж ажилласан. Хөшөө дурсгалд засвар, шинэчлэлтийн ажлыг зохион байгууллаа. Соёлын биет болон биет бус өвийг таних, бүртгэх, мэдээллийг шинэчлэх, www.ichmogoluv.mn программ хөгжүүлэлтийг сайжруулах сургалтыг зохион байгуулж 43 нийгмийн ажилтныг хамруулснаар программын шинэчлэлт 90 хувьтай хийгдээд байна. Дүүрэг орон нутгаа иргэд, жуулчдад таниулан сурталчлах зорилгоор танилцуулгыг англи, монгол хэл дээр эх бэлтгэлийн ажил хийгдэж байна.</p>	
<p>2.6.Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, хөгжил хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг бий болгоно.</p>			
48	<p>2.6.1.Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, хөгжил хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан 6 удаагийн чадавхжуулах сургалт, арга зүй өгөх нэгдсэн арга хэмжээнд 43 хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багийн 84 гишүүн, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгаалалын хэлтсийн 10 албан хаагч хамрагдсан. Нийт 5 удаагийн кейс хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 215 хорооны нийгмийн ажилтныг хамрууллаа. Нийт сургалт, арга хэмжээнд 296 албан хаагчийг хамруулж, чадавхжууллаа. "Дэлхийн нийгмийн ажилтнуудын өдөр"-ийг тохиолдуулан нийгмийн ажилтнуудын дунд "Social work confereпсе - 2025" арга хэмжээг зохион байгуулж, нийт 350 гаруй албан хаагчдыг хамруулсан. Монгол улсын Боловсролын Их сургуулийн Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран 43 хорооны нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж сертификат олгосон. Мөн бүх салбарын нийгмийн ажилтнуудын дунд "Нийгмийн ажил үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдэл, арга зам" эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зарлаад байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан дүүргийн хүүхэд, багачуудад зориулсан "МОНГОЛ ХҮҮХДҮҮД" нэгдсэн арга хэмжээг "Улсын Хүүхэд, залуучуудын театр"-ын гадна талбайд хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон 2 төрлийн хөтөлбөрт хувааж зохион байгууллаа. Арга хэмжээнд дүүргийн 43 хорооны нийт 6000 гаруй хүүхэд, багачууд оролцож, хөгжлийн бэрхшээлтэй 1000 хүүхдэд баярын бэлэг гардууллаа.</p>	20.0

49	2.6.2.“Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг дэмжиж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үзүүлнэ.	“Түр хамгаалах байр”-нд тайлант хугацаанд шинээр 162, үргэлжлүүлэн 9, нийт 171 хүүхэд хүлээн авч амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалан тодорхой хугацаагаар байрлуулан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Нийт насанд хүрсэн 4 иргэн, 171 хүүхдэд давхардсан тоогоор 1865 ор хоногийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан. Тус хамгаалах байрны зардалд 687.2 сая төгрөгийн дэмжлэгийг олгоод байна. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг гэрээр эргэх “Хяналт” арга хэмжээг дүүргийн 43 хорооны хамтарсан багийн 154 албан хаагч, 393 хэсгийн ахлагч, 1839 анги удирдсан багш, нийт 2386 албан хаагч 1897 хүүхдийн нөхцөл байдлыг тодруулан ажиллаж, хүүхдийн гэрээр айлчлах хугацаанд 93 зөрчлийг илрүүлэн холбогдох байгууллагад холбон зуучилж ажилласан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран эрсдэлт нөхцөлд байгаа, тэр дундаа бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ шаардлагыг ойлгуулах замаар сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ, арга зүйн дэмжлэг үзүүлэх богино хугацааны төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 6 удаагийн сургалт, 15 удаагийн зөвлөх үйлчилгээг үзүүлсэн ба 2026 оны 04 дүгээр сар хүртэл үргэлжилнэ. Хүүхэд үрчлэлтийн 95, асран хамгаалагч тогтоох 57, харгалзан дэмжигч тогтоох 24, асрамжид асруулах 3, ар гэрт нь эргэн нэгтгэх 5, нийт 186 хүүхдийн өргөдөл, хүсэлт, материалыг хянаж холбогдох хууль тогтоомжийн дагуу дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэр гарган, хяналт тавин ажиллаж байна.	20.0
50	2.6.3.Залуучуудын хөгжлийг дэмжих, өсвөр үе, залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлнэ.	“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 32 дугаар тогтоолоор батлуулж, 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд “Мөрөөдөлд хүрэх зам” ахлах ангийн сурагчдын манлайлах, нөлөөлөх, бүтээлчээр сэтгэх, мэргэжил сонголттой холбоотой, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох ур чадварыг хөгжүүлэх, өсөж дэвжих хандлага суулгах зорилготой цуврал арга хэмжээг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж, дүүргийн ерөнхий боловсролын 26 сургуулийн нийт 2000 гаруй ахлах ангийн сурагчдыг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод зориулсан “Мэргэжил сонголтод хиймэл оюун ухаан нөлөөлөх нь” сэдвийн хүрээнд программ хөгжүүлэх, код бичих, дижитал зах зээлийн мэдлэг олгох дадлага ажилд суурилсан цуврал танхим, лекц хосолсон сургалтыг зохион байгуулж 26 сургуулийн 10-12 дугаар ангийн 1318 сурагчдыг хамруулснаас практик сургалтад 625 сурагчид оролцож цахим хэрэглээний программ AI хиймэл оюун ухааны анхан шатны мэдлэгийг эзэмшлээ.	25.0

		“YOUTH TRAINER” сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг 2 үе шаттайгаар зохион байгууллаа. Хөтөлбөрийн 1 дүгээр шат сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж 70 гаруй залуус бүртгүүлснээс шалгуур үзүүлэлт хангасан 30 залууг вакумжуулсан хөтөлбөрт хамруулж сертификатжууллаа. Хөтөлбөрийг амжилттай төгссөн сургагч багш нар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон хороодын нийт 400 гаруй алба хаагчдад “Байгууллагын соёл-Харилцаа хандлага” сэдвээр бүсчилсэн сургалт хийсэн ба сургагч багш нар 40 цагийн сургалт зохион байгуулж, тайлагнаснаар үндэсний сургагч багшийн сургалтад хамрагдах эрхтэй болохоор бэлтгэгдэж байна.	
51	2.6.4.Залуучуудын хөгжлийн үйлчилгээний төвийг байгуулж, залуу гэр бүлийг дэмжиж ажиллана.	Хүүхэд, залуучуудын хөгжлийн үйлчилгээний төвийг байгуулахаар Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, хэлэлцээрийн төвшинд ажиллаж байна. Залуу гэр бүлийг дэмжих арга хэмжээний хүрээнд “Эрүүл, жаргалтай гэр бүл” нөлөөллийн үйл ажиллагааг цуврал байдлаар 2 удаа зохион байгуулж нийт 43 хорооны залуу гэр бүлийн төлөөлөл 300 гаруй иргэдийг хамруулсан. “Дайманд Майнд” академитай хамтран “Жаргалтай ээж” сэдэвт сургалтыг зохион байгуулж, дүүргийн 43 хорооны зорилтод бүлгийн 150 гаруй ээжүүдийг оролцуулж, мэдээ, мэдээллээр ханган, зөвлөгөө өглөө. “ХАЙР ӨВТГӨХ УЧИРГҮЙ 1” нөлөөллийн арга хэмжээг Гэрлэх ёслолын өргөөтэй хамтран зохион байгуулж Цагдаагийн газрын давтамжтай дуудлага мэдээлэлтэй 20 өрхийн 50 иргэнийг хамруулж “Хайр дүүрэн гэр бүл” сэдвээр МУ-ын гавьяат жүжигчин Н.Ариунболд илтгэл хэлэлцүүлж, ярилцлага хийсэн. Сургалтын үр дүнгийн судалгааг Цагдаагийн газартай хамтран 11 дүгээр сард багтаан гаргаж, олон нийтэд танилцуулахаар бэлтгэл хангаж байна. “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Засаг даргын Тамгын газар, “Нарру art” урлантай хамтран “Гэр бүл - хамгийн сайхан бүтээл” арт терапи буюу урлагийн сэтгэл заслын хөтөлбөр”-ийг хэрэгжүүллээ. Тус арга хэмжээ нь албан хаагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих, стрессийг бууруулах зорилготой, нийт 50 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан. Тайлант хугацаанд 21 хосын хуримын ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.	10.0
2.7.Иргэдэд жендерийн боловсрол олгох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг хэрэгжүүлнэ.			
52	2.7.1.“Жендерийн эрх, тэгш байдлыг хангах” дүүргийн төслийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, салбар хоорондын уялдааг ханган хэрэгжүүлнэ.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны А/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн 2024-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд “Жендер ба жендерийн мэдрэмжтэй бодлого, статистик” сургалт, “Харилцан хүндэтгэе” аяныг зохион байгуулж, багш нарын жендерийн ойлголт, хандлагыг үнэлэх судалгааг цахимаар хийлээ.	20.0

		<p>Жендерийн сургалтад харьяа 70 байгууллагын удирдлага, жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, аяны үйл ажиллагаанд 91 байгууллага оролцож, үйл ажиллагаагаа тайлагнасан. Багш нарын жендерийн ойлголт, хандлагыг үнэлэх судалгаанд 1096 багш, албан хаагчид хамрагдсан. Жендерийн эрх, тэгш байдлыг хангах хууль, дэд хөтөлбөр, жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг танилцуулах арга хэмжээг 5 удаа зохион байгууллаа. Ажил олгогчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцсон 450 гаруй аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын 29 удирдлагад 2 удаа, “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан Child.mn сайттай хамтран Нэгдсэн эмнэлгийн бодлогын видео танилцуулгыг хийж цахимаар олон нийтэд түгээгээд байна. Төрийн ордонд зохион байгуулсан “Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийн тайлан” нэгдсэн арга хэмжээнд “Тесо групп” оролцож, бодлогоо танилцуулж, туршлагаа хуваалцлаа. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа үндэсний шинжээч бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж, гэрчилгээгээ гардан авсан ба Сэлэнгэ аймагт Ментороор ажиллаж дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлж байна. Хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хорооны Ментортой хамтран 5 байгууллагын дотоод журам, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийлээ.</p>	
53	<p>2.7.2.“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг арилгах” стратеги төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ.</p>	<p>“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг арилгах” дүүргийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд өвөр насны охидоос өсвөр насныхны эрүүл мэнд, жендерт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэгийг тандах судалгааг цахимаар хийлээ. Судалгаанд 1414 охин хамрагдсан ба үр дүнд суурилсан арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг арилгах” батлагдсан төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, хороо, сургууль, цэцэрлэг, нийт 113 байгууллагад хүргүүлэн, танилцуулсан. Эрэгтэй хүний чанартай насжилтийг дэмжих зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн 51 удаагийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 2136 иргэнийг хамруулан, 528 өвчлөлийг илрүүлж 355 хүнийг эрүүлжүүлээ. Дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагын хяналтад 173 хүнийг илгээгээд байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 119 буюу 5.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.</p>	20.0

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ.

54	3.1.1.Дүүргийн татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд хүртээмжтэй байдлаар технологийн дэвшил ашиглан нэмэгдүүлэх, татварын үйлчилгээг цахимжуулах, цахим татвар хураалтын орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.	Дүүргийн хэмжээнд 1,112 татвар төлөгч Аж ахуй нэгж байгууллага, иргэдийг “Цахим татварын систем”, “Цахим төлбөрийн баримтын систем”-д холбосон. Татварын тайлан тушаалт, татварын ногдлыг цахимжуулснаар 2025 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт татварын орлогын 89 хувь буюу 145,266.8 сая төгрөгийг цахимаар төвлөрүүлсэн байна. Энэ нь 2024 оны мөн үетэй харьцуулахад цахим татвар төлөлт 16,657.9 сая төгрөгөөр буюу 11.0 хувиар нэмэгдсэн байна.	25.0
55	3.1.2.Татварын тайлагналт, хураалт, хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой мэдээ мэдээллийг иргэд, татвар төлөгчдөд уламжлалт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж, татварын үйлчилгээг татвар төлөгчдөд хүртээмжтэй, ил тод байдлаар хүргэж, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.	Татварын тухай хууль, татварын тайлан болон төлөлтийн талаар 4 төрлийн мэдээ, мэдээлэл, контентыг бэлтгэн UBS телевиз, Сонгинохайрхан мэдээ, Татварын цахим хуудсуудаар дамжуулсан бөгөөд 5 нэр төрлийн албан татварын төлөлт, тайлан тушаалтын хугацаатай холбоотой мэдээллийг давхардсан тоогоор 91,337 татвар төлөгчдөд мессежээр хүргүүлэн ажилласан байна. Тайлант онд дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 158 татвар төлөгчийг шинээр бүртгүүлсэн байна. Татвар төлөгчдийн өдрүүд болон татвар төлөлт, тайлагнах, татварын хууль тогтоомжийг таниулж танхимын 12 удаагийн сургалтаар 510 аж ахуйн нэгж, цахимын 18 удаагийн сургалтад 254 иргэн, сургуулийн 703 сурагчдыг хамруулан зохион байгуулан ажилласан.	25.0
56	3.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	Дүүргийн хэмжээнд 2025 оны 3 дугаар улирлын Шилэн дансны хяналтаар 117 байгууллагын 15,411 мэдээллийг Шилэн дансны сайтад байршуулахаас 15,200 мэдээллийг хуулийн хугацаанд, 211 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан ба мэдээлэл хоцроон байршуулсан нийт 82 байгууллагын санхүүгийн ажилтанд сануулга өгч ажилласан. Гүйцэтгэл 98.6 хувьтай.	25.0
57	3.1.4.Төсвийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт түүний үр ашигтай байдалд хяналт тавьж, санхүү тайлан бүртгэлийн стандарт, санхүүгийн сахилга бат, санхүүгийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүждэг 117 байгууллагад 133,755.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Улс, орон нутгийн 137 байгууллагын 300 зарлагын дансны 33,828 төлбөрийн баримтын дагуу 410,900.0 сая төгрөгийн гүйлгээнд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд 250 Санхүү бүртгэлийн ажилтнуудыг сургалтад хамруулан мэргэшүүлсэн болно. 2025 онд Шилэн дансны аудитаар орон нутгийн 12, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, албан бус насан туршийн боловсролын төв 1, цэцэрлэг 71, хүүхдийн сэргээн засах төв 1 бүгд 117 байгууллага шилэн дансны мэдээллийг байршуулан	25.0

		ажиллаж байна. Нийт 15,411 мэдээлэл байршуулахаас 15,200 мэдээллийг хуулийн хугацаанд, 211 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 6 мэдээлэл хуулийн хугацаанд байршуулаагүй байна. Мэдээллээ хоцроон байршуулсан нийт 82 байгууллагын санхүүгийн ажилтанд сануулга өгч ажилласан байна.	
58	3.1.5.Төсвийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, саналыг тусган боловсруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд ил тод мэдээлнэ.	Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс иргэдээс авах санал асуулгыг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.2-т заасны дагуу цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулсан. Иргэдээс авах цаасан санал асуулгыг Төсвийн тухай хууль, журмын хүрээнд иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэл рүү түлхүү анхаарч 13 асуулгатайгаар бэлтгэн 100,000 ширхэгийг хэвлүүлж 43 хорооны өрхийн тоонд харьцуулан хуваарилан өгч 2025 оны 4 дүгээр сарын 15-аас 6 дугаар сарын 15-ны хооронд авч саналыг нэгтгэсэн. Санал асуулгын дүнг үндэслэн 180 төсөл арга хэмжээний зураг, төсвийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэгт заасны дагуу Дүүргийн 2026 оны төсвийн төслийг олон нийтэд танилцуулж, орон нутгийн иргэдийн санал, хүсэлтийг тусган боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.	25.0
59	3.1.6.Дүүргийн хог хаягдал, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, тохижилтын менежментийг сайжруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудын зарим чиг үүргийг хувийн хэвшилд үе шаттайгаар шилжүүлнэ.	<p>Дүүргийн хэмжээнд нийт 23 Аж ахуй нэгж байгууллага Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 23 багц тендерт шалгаран 18,109.6 сая төгрөгийн гэрээг байгуулан ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар 15,091.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдал тээвэрлэлт: 43 хорооны 20 хороо буюу 46.5 хувийг 7 хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага; • Нийтийн эзэмшлийн зам цэвэрлэгээ: нийт 4,026,699 м2 нийтийн эзэмшлийн зам талбайн 2,050,840 м2 буюу 50.9 хувийг 7 Хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага; • Ногоон байгууламжийн арчлалт: нийт 73,008 м2 ногоон байгууламжийн талбайн 68,839 м2 буюу 94.3 хувийг 4 Хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага; • Гэрэлтүүлгийн урсгал засвар: 25,256 нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг 100 хувь 4 Хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага; • Нохой, муурын устгал: 1 Хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага 100 хувь хариуцан ажиллаж байна. 	25.0

60	3.1.7.Орон нутгийн өмч, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган, удирдлагын менежментийг сайжруулж, өмчийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас эд хөрөнгийг нэгдсэн бүртгэлд хамруулж бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-г улсын хэмжээнд нэвтрүүлж байгаатай холбогдуулан дүүргийн төсөвт 117 байгууллагын эд хөрөнгө хариуцагч нарыг нэгдсэн сургалтад хамруулан эд хөрөнгийг цахим системд бүртгэх ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дүүргийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих нийт 22,354.9 сая төгрөгийн 116 төсөл, арга хэмжээ батлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гүйцэтгэгчийг шалгаруулан 110 байгууллагад мэдэгдэл хүргүүлэн, 20,488.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 11,303.2 сая төгрөгийн 80 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 9,184.9 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээ комисс ажиллаж гүйцэтгэлийн баримт бүрдэл ханган ажиллаж байна.	25.0
3.2.Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийг инновац нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.			
61	3.2.1.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал аяны хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдан Өв соёл үйлдвэр ХХК-ны “Өв соёл” брэндийн 15 нэр төрлийн нарийн боов үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Мах импекс ХК хүүхдэд зориулсан бяслагтай салами, эко банш гэсэн 2 төрлийн шинэ бүтээгдэхүүн нэмэгдүүлсэн. Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж 2 борлуулалтын цэгийг нээсэн. Үүнд: Соёолж молл худалдааны төв 28 м2 талбайд 6 үйлдвэр эрхлэгч, Драгон терминал Имарт худалдааны төвийн 35м2 талбайд 15 үйлдвэр эрхлэгч нийт 21 үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг байршуулан Сонгинохайрхан мэдээ, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн цахим хуудсаар сурталчлан борлуулалтыг нэмэгдүүлж ажиллаж байна. Тайлант хугацаанд 78.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. ТҮЦ эрхлэгч иргэдийн төлөөлөлтэй уулзаж ажлын байранд зуучлагдах өөр байршил, объектод худалдаа эрхлэх хүсэлт өгсөн иргэдийн судалгааг авч 10 иргэнийг драгон худалдааны төвийн Б1 давхарт талбай гарган өгч дэмжлэг үзүүлсэн. Бичил жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 70 ЖДҮэрхлэгчийг томоохон үйлдвэрүүдээр туршлага судлуулан, мэдээлэл солилцох, практик сургалтыг зохион байгуулсан.	20.0
62	3.2.2.Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлан таниулах,	Нийт гадаад, дотоодын 18 удаагийн үзэсгэлэн худалдаанд 303 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж 702.4 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. -БНСУ-н Сөүл хотын “Мега шоу-2025” үзэсгэлэн худалдаанд 8 үйлдвэрлэл эрхлэгч -БНХАУ-ын Хайлаар хотын “Олон улсын” үзэсгэлэнд 4 үйлдвэрлэл эрхлэгч	25.0

	<p>үйлчилгээний салбар бүрийн онцлогтой уялдуулан төрөлжсөн сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</p>	<p>-Япон улсын Изүнокүни хотод “Монгол-Японы соёлын өдөрлөг” үзэсгэлэнд 4 үйлдвэрлэл эрхлэгч - “Амар байна уу 2025” үзэсгэлэн худалдаанд 84 үйлдвэрлэл эрхлэгч - “Сар шинэ-2025” үзэсгэлэн худалдаанд 35 үйлдвэр эрхлэгч - “ИХ ХОТЫН БҮСГҮЙЧҮҮД 2025” үзэсгэлэн худалдаанд 1 үйлдвэр эрхлэгч - “Нарны баяр-2025” үзэсгэлэн худалдаанд 8 үйлдвэр эрхлэгч - ХХААХҮ яам үзэсгэлэнд 7 үйлдвэр эрхлэгч - “Үл тасрах өв 2025” үзэсгэлэн худалдаанд 32 үйлдвэрлэл эрхлэгч - “Ажилтай, орлоготой гэр бүл” 6 үйлдвэр эрхлэгч - “Ажил олгогчдын уулзалт, зөвлөгөөн”-д 5 үйлдвэр эрхлэгч - “Эрүүл амьдрал, эрүүл бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд 14 үйлдвэр эрхлэгч - Дэлхийн итгэмжлэлийн өдөр үзэсгэлэнд 12 үйлдвэр эрхлэгч - Asian folk үзэсгэлэн худалдаанд 18 үйлдвэр эрхлэгч - Хүрээ цам-Даншиг наадам 2025 үзэсгэлэнд 37 үйлдвэр эрхлэгч - Наадам 2025 үзэсгэлэнд 13 үйлдвэр эрхлэгч - Нүүдэлчин-2025 үзэсгэлэнд 16 үйлдвэр эрхлэгч - “Монгол-Япон соёлын өдөрлөг” үзэсгэлэнд 12 үйлдвэр эрхлэгчийг хамруулсан. Бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг олгох, хөгжүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 26 удаагийн 518 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж ажилласан.</p>	
<p>3.3.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлж, үйлчилгээний байгууллагуудын стандартыг мөрдүүлнэ.</p>			
63	<p>3.3.1.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг байгуулж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.</p>	<p>Дүүргийн 29 дүгээр хорооны нутаг дэвсгэр хуучнаар Сүлжмэлийн үйлдвэрийн урд 17 ТҮЦ-ийг чөлөөлж, 4600 м2 талбайд худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж явуулын үйлчилгээ бий болгох саналыг нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлсэн. Уг талбайд “Хичээлийн шинэ жил”-ийн үзэсгэлэн худалдааг 2025 оны 08 дугаар сард зохион байгуулж, Анар текс ХХК, Соёмбо Принтинг ХХК зэрэг үндэсний үйлдвэрлэгч хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцасны 15 аж ахуйн нэгж, иргэн, өрхийн тариалан эрхлэгч 16 иргэдийг оролцуулж асарыг түрээсгүйгээр байршуулж 35.0 сая төгрөгийн борлуулалт хийгдэж жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллалаа.</p>	10.0
64	<p>3.3.2.Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудын стандартыг хангуулна.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар гадна хаяг тохижилтын чиглэлээр 44 зөрчлийг бүртгэн Сэнтий зочид буудал, ЭССО зочид буудлын гадна хашаа, 11 контейнерыг ачуулж, хогийн сав гадна фасад засварлах чиглэлээр хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулж ажилласан. 18 дугаар хороо “Ар улаан чулуу” ХХК-ний дэн буудлын явган хүний зам руу орсон шатыг буулгуулж 29 зочид буудал, дэн буудлын</p>	25.0

		<p>хаягийг шинэчлүүлж, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Нийслэлийн ХХААГ-ийн хяналтын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газруудад стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалт явуулсан. Шалгалтад Мана индра ХХК, Амьд байгаль ТББ, Элма баян-Уул ХХК, Самбарай ХХК, Сонгинохайрхан амралт цогцолборын газар, Ус сувгийн удирдах газрын харьяа амралтын газар, Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Сүүж уул амралт, сувиллын газар, Шинэ өргөө дэвжих трейд ХХК, Ординат ХХК, Тайванбаатар ХХК зэрэг амралтын газрууд хамрагдаж илэрсэн 18 зөрчлийг арилгуулах хугацаатай мэдэгдэл хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан. Мана индра ХХК-ны Мана амралт, Элма баян-Уул ХХК-ны баян уул амралтууд бохир соруулах системийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр шинэчилж дуусгасан.</p>	
<p>3.4.Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулна.</p>			
65	<p>3.4.1.Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад салбарын хууль тогтоомж түүнтэй нийцүүлэн төрөөс гаргасан журам, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулна.</p>	<p>Дүүргийн Цагдаагийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтэстэй хамтран холбогдох хуулийн хэрэгжилт, насанд хүрээгүй хүнд электрон тамхи худалдаалахгүй байх, цахим залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагад иргэдээс ирж буй дуудлага, мэдээлэл нь аж ахуйн нэгжийн регистрийн дугаар дээр бүртгэгдсэнээр гарч болох эрсдэл, нөхцөл, шалтгааныг танилцуулах чиглэлээр худалдаа, хоол үйлдвэрлэлийн 696 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан, 4 удаа сургалт зохион байгуулж, мэдэгдэл, боршур тараасан. Худалдаа, үйлчилгээний салбарт шинээр хэрэгжиж буй хууль тогтоомж, захирамж, шийдвэрийн талаар аж ахуйн нэгжүүдэд цахим группээр тухай бүр мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>Худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, журам, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих шалгалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс болон бусад холбогдох байгууллагууд хамтран 11 удаа зохион байгуулж, 901 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Шалгалтаар зохих зөвшөөрөлгүй тамхи, согтууруулах ундаа худалдан борлуулсан, түүгээр үйлчилсэн 14 иргэн, аж ахуйн нэгжийн зөрчилд Цагдаагийн байгууллагаас 3.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, эд зүйлсийг хураан Дүүргийн орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Нийтийн эзэмшлийн зам талбайд үйл ажиллагаа явуулж байсан 108 явуулын хоолны үйлчилгээ, ТҮЦ, 30 ил задгай худалдааг бүрэн буулгаж ажилласан.</p> <p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийн хүрээнд</p>	25.0

		Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2024 оны А/219 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны А/126 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох санал дүгнэлт гаргах чиглэлээр 2025 онд 14 удаагийн хурлаар худалдааны 131, хоол үйлдвэрлэлийн 40, нийт 35 удаагийн хурлаар стандартын болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангасан худалдааны 542, хоол үйлдвэрлэлийн 110, нийт 652 аж ахуйн нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох санал дүгнэлт гаргасныг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу шаардлага хангасан 18 иргэн, 154 хуулийн этгээдэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.	
66	3.4.2.Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын стандартын хэрэгжилтийг хангуулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	33 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “ОБ Пластик” ХХК нь “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдан ажлын байрыг 2500 болгон нэмэгдүүлж, дотоодын зах зээлийн 50-60 хувийг хангах хүчин чадалтайгаар түүхий эдийн зарцуулалт багатай, байгальд ээлтэй дахин боловсруулах боломжтой 14 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Ногоон сав баглаа боодлын хөтөлбөр”, “Борлуулалтын хүч” зэрэг хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, 43 бизнес эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний чанар, имижийг шинэ түвшинд хүргэж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. 12 үйлдвэрлэл эрхлэгч сав баглаа боодол, шошгыг хэрэглэгч төвтэй, байгальд ээлтэй болон стандарт шаардлагын дагуу хэрхэн хөгжүүлэх, зах зээлийн судалгааг хийх аргачлалд суралцаж сонгосон бүтээгдэхүүнийхээ сав баглаа боодол, шошгыг шинэчлэх эхний загвар, төлөвлөгөөг гаргасан. Амин элч брэнд, Өнөр алтхан брэнд, Манна брэнд, Малгайт брэнд, Анара брэндүүд СУ сүлжээ дэлгүүрт борлуулалт хийж хамтран ажиллах гэрээ байгуулсан.	15.0
67	3.4.3.Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, үйлчилгээний стандартыг хангуулж иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.	Нийслэлийн хүн амын махны хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний хүрээнд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх 4 компанийн махны чанар, хадгалалт, савлалт, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй эсэхэд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран үзлэг хяналт, шалгалт явуулж, бэлэн байдлыг хангуулж ажилласан. Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан нөөцийн махны өргөтгөсөн худалдаанд оролцсон мах бэлтгэн нийлүүлэгч компаниудын ажиллагсдын ажлын хувцасны хэрэглээ, махны чанар, эрүүл ахуй, зориулалтын техникээр тээвэрлэж буй байдалд хяналт тавьж ажиллалаа. 97 байршилд өргөтгөсөн худалдаагаар 700.8 тн хонины, 259.1 тн үхрийн, нийт 960 тн мах худалдан борлуулсан байна.	20.0

68	3.4.4.“Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан, хоол хүнсний зөв зохистой, соёлтой хэрэглээний талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	“Үндэсний хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо”-той хамтран хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 113 аж ахуйн нэгжийн бармен, ажиллагсдад “Хариуцлагатай үйлчилгээ эрхлэгч” сертификат олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар соёлтой үйлчилгээг үйлчилгээндээ дэлгэрүүлэх, үйлчлүүлэгч хэт архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар холбогдох хуулийн зүйл заалтыг танилцуулан, мэдлэг олгосон.	15.0
69	3.4.5.Газар тариалан, өвлийн хүлэмжийн аж ахуйн тариалалтыг кластераар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Дүүргийн хэмжээнд 48 аж ахуй нэгж, 467 иргэн газар тариалан эрхлэж, 717 га талбайд төмс, хүнсний ногоо, ногоон тэжээл тариалан 5009 тн ургац хураан авсан. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг 28 аж ахуй нэгж, 278 иргэн 98,354 м2 талбайд эрхэлдэг. Үүнээс 8 аж ахуй нэгж, 2 иргэн 57,050 м2 талбайд өвлийн хүлэмжийг шинээр барьж, өвлийн хүлэмжний тариалалтыг өргөжүүлсэн. Атрын 4 дүгээр аяны хүрээнд өвлийн хүлэмжийн аж ахуй эрхэлдэг 4 аж ахуй нэгж 180.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлд хамрагдсан. Хүнсний ногооны урамшуулалд 3 аж ахуй нэгж, 2 иргэн 975.3 тн хүнсний ногоо зах зээлд борлуулж, 97.5 сая төгрөгийг авсан.	25.0
70	3.4.6.Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт мал, амьтны өвчлөлийн эрсдэлийг бууруулна.	2025 онд мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх 16 арга хэмжээг зохион байгуулж нийт 366,486 толгой мал, амьтан хамрагдсан. Мал эмнэлгийн гарал үүслээр 238 мал орж ирсэн бол гадны аймаг, сумдад оторлохоор 284 мал шилжсэн. Малаас хүнд халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Бруцеллёз өвчин илрүүлэх цусны дээжийг 9356 үхэр/ хээлтэгч/, 79 хээлтүүлэгчээс, 332 өрхийн 5342 үнээнээс сүүний дээж авч шинжилгээнд хүргүүлсэн. Халдварт болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлж 2369 мал, амьтны сэг зэмийг устгаж, 657,821 м2 хашаа хороо, худаг уст цэг, устгалын цэгийн талбайд ариутгал хийсэн.	25.0
71	3.4.7.Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр малын үүлдэр угсааг сайжруулж, сүүний үхрийн аж ахуйг кластерийн системээр хөгжүүлэх менежментийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хийнэ.	Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 17,219 толгой үхэртэй 537 өрх үйл ажиллагаа явуулж байна. Малыг чанар сайжруулах зорилгоор Малыг удмын сангийн үндэсний төв, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 124 өрхийн 690 хээлтэгч малд зохиомол хээлтүүлэг хийсэн. Цэвэр үүлдрийн болон сайжруулсан үхэр сүргийг өсгөн үржүүлж байгаа 52 иргэн, 4 аж ахуй нэгжийг сонгон 1200 үхрийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн. Мал аж ахуйн 16 хоршоо сүү, сүүн бүтээгдэхүүн болон мал аж ахуй чиглэлээр 576.0 сая төгрөгийн зээл авч тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Энэ онд 1580 фермер эрхлэгч иргэн, аж ахуй нэгж 4.6 тэрбум төгрөгийн сүүний урамшуулалд хамрагдсан.	20.0

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдол доройтлыг бууруулж, иргэдийн аюулгүй байдлыг хангана.

72	4.1.1.Тохижилт бүхий бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.	<p>Дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайн авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 3, 4, 6, 15, 18, 19, 25, 26, 27, 28, 29, 33, 43 дугаар хороодын нутаг дэвсгэрт 15,619 м2 авто зогсоолыг шинээр хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2240 м2 авто зогсоол байгуулж, нийт 17,659 м2 авто зогсоолыг ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 22, 30 дугаар хороодын нутаг дэвсгэрт 3938 өрх, 411 гудамжны хаягжуулалтын ажлыг шинээр хийсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 10 байршилд дулаан автобусны буудлыг шинээр байгуулсан. Дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2561 м2 талбай бүхий “Спортын цогцолбор”-ыг ашиглалтад оруулсан.</p> <p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 12, 14, 22 дугаар хороодын нийтийн эзэмшлийн талбайд гадна тохижилтын ажлыг шинээр хийж ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1, 4, 15, 16, 35 дугаар хороодын нутаг дэвсгэрт 6 байршилд нийтийн эзэмшлийн гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. НЗД-ын “Нийтийн эзэмшлийн зам талбайн эвдрэл гэмтэл, орчны аюулгүй байдлыг хангуулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах талаар зарим арга хэмжээний тухай” А/560 дугаар захирамжийн хүрээнд 43 хорооны нутаг дэвсгэрт 88 байршилд тохижилтын ажил 100 хувь хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр “Улаан чулуутын хогийн цэг”, “Бөөр булаг орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар”, Бумбатын рашаан”-д нийт 7851 метр урт хашаа, хайс хийсэн.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 11 хорооны нутаг дэвсгэрийн 2140.4 м2 талбайд хашаа хайсыг будаж, өнгө үзэмжийг сэргээсэн.</p>	25.0
73	4.1.2.Шинээр байгуулах тоглоомын талбайг стандарт шаардлагад нийцүүлж, засвар үйлчилгээг тогтмолжуулан хүүхдэд аюулгүй орчныг бүрдүүлнэ.	<p>Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчныг сайжруулах зорилгоор 2, 8, 10, 11, 12, 13, 22, 27, 32, 34, 35, 41, 42 дугаар хороодод хүүхдийн тоглоомын талбай засварын ажил хийгдэж дууссан. Хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдалд хяналт шалгалт хийж 13 байршлын 83 төрлийн тоног төхөөрөмжийг актлах шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж хариуцагч байгууллагад хүргүүлсэн. 3, 31, 39 дүгээр хороодод дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тоглоомын талбайг шинээр байгуулж, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6 байршилд 4, 16, 20, 21, 38 дугаар хороодод хүүхдийн тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	25.0

74	4.1.3.Нийтийн эзэмшлийн талбай, явган хүний замыг нэмэгдүүлэн сул шороон хөрс бүхий талбайн хэмжээг бууруулна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7, 8, 11 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн талбайд 1547 м2 явган зам, дүүргийн төсвийн хөрөнгөөр 27, 29 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 2050 м2 талбайд явган хүний замыг шинээр хийж гүйцэтгэсэн. Орон сууцны хорооллын дундах нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоолын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3694 м2 явган зам шинээр хийгдсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8, 15, 18, 20, 25, 27, 35, 43 дугаар хороодын нутаг дэвсгэрт, нарийн гудамжинд 1410 м2 явган хүний замыг хуучин хавтангаар хийж тохижуулсан. 2025 оны Нийслэлийн Засаг даргын А/01 захирамжаар “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн хэмжээнд Нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иж бүрэн авто зам, явган зам, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт бүтээн байгуулалтууд дээр хийгдсэн явган замын нэгдсэн тоон мэдээлэл үндэслэн 19 хорооны / 4, 5, 7, 8, 11, 15, 18, 20, 25, 27, 28, 29, 30, 35, 39, 41, 43/ нийтийн эзэмшлийн талбайд нийт 19,478 м2 явган замыг шинээр болон засвар шинэчлэлтийг хийсэн.	25.0
75	4.1.4“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот- Иргэдийн оролцоо” аяны хүрээнд 2025 оны мод тарих ажлыг зохион байгуулах тухай Дүүргийн Засаг даргын А/283, А/625 дугаар захирамжуудын хүрээнд хавар, намрын мод тарих, арчилгаа, усалгааг өрнүүлэх ажлыг 5, 10 дугаар саруудад зохион байгуулж, давхардсан тоогоор 43 хорооны 12520 иргэн, 681 аж ахуйн нэгж байгууллагын 8981 орчим ажилтан албан хаагчид оролцож, 15 нэр төрлийн 93,631 тарьц суулгацыг 473,370 м2 талбайд тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.	25.0
76	4.1.5.Суурьшлын бүсийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн бичил цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, иргэдийн ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүсмэл хогийн цэгийг цэвэрлэсэн 38 га талбайд 3110 метр урт хамгаалалтын хашааг барьж, хаврын тарилтаар 10,000, намрын тарилтаар 2150 мод, бут, сөөгний суулгацыг тарьж, нийт 12,150 суулгацыг тарьж ойн зурвас байгуулсан. Ойн зурвасын арчилгаа, усалгаа, нөхөн тарилтын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Цагдаа толгой цэцэрлэгт хүрээлэнд 12,526 ширхэг, Бумбат төгөлийн ногоон байгууламжийн талбайд 207 ширхэг, Бумбатын рашааны орчимд 1650 ширхэг нийт 7 нэр төрлийн суулгацыг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, арчлалт хамгаалалт, нөхөн тарилт, хашаа, хайс сэргээн засварлах, ажлуудыг хийж гүйцэтгүүлэхээр “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	25.0

77	4.1.6.Хөв цөөрөм, усан сан байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнтэй байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд Баруун салааны үерийн усны эрчмийг бууруулах, усны нөөцийг хуримтлуулах, усан сан цөөрмийн зураг төсөв боловсруулах ажлын 2023-03/84 дугаартай гэрээг байгуулж, 1.5 тэрбум төгрөгийн зураг, төсвийг хүлээлгэн өгсөн. Байгаль орчны яам, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Сонгинохайрхан дүүргийн засаг даргын Тамгын газартай хамтран НҮБ-ын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөр буюу НҮБ-ын Хабитат төсөл 2023 оноос эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжиж байна. 26 дугаар хорооны 93 нэгж талбарын 2025 онд бүрэн чөлөөлүүлсэн. Хөв цөөрмийн ажил 85 хувьтай, 26, 27 дугаарын хорооны нутаг дэвсгэрт тохижилт бүтээн байгуулалт, явган хүний 3 ширхэг гүүр хийгдсэн.	20.0
78	4.1.7.Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.	Дүүргийн 2, 11, 25 дугаар хороодын цогцолбор байранд НҮБ-ын төслөөр ахуйн бохир ус цэвэрлэх эко төхөөрөмжийг “Эколос алтай” ХХК байрлуулах ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Дүүргийн хэмжээнд хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл хүссэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгааг гарган 18 аж ахуйн нэгжтэй хаягдал ус, хаях зайлуулах зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	15.0
79	4.1.8.Иргэн аж ахуй нэгж байгууллагын ногоон байгууламж нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжиж, урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран “Хашаандаа 5 мод” аяны хүрээнд гэр хорооллын 32 хорооны 1440 өрхөд 7200 тарьц суулгац тарих ажлыг хийж гүйцэтгэн e.mongolia.mn-д бүртгэн цахимжуулж, ургалтын үр дүнг харгалзан дата багцаар урамшуулах ажлыг эхлүүлсэн. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх санал санаачлагыг дэмжих зорилгоор хашаандаа мод тарьж урамшуулал олгох тухай 11 зүйл, 21 заалттай журмын төслийг боловсруулж, удирдлагуудад танилцуулан нөлөөллийн шинжилгээ хийлгэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	10.0
80	4.1.9.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтыг суурьшлын бүсэд хязгаарлан, биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг хийлгэнэ.	Дүүргийн 11 хороонд 37 аж ахуй нэгж Түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэлтэй байна. 2025 онд 9 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж, 13 аж ахуй нэгж зогссон, 15 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлээгүй байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах, ногоон байгуулмж нэмэгдүүлэх ажлын хүрээнд 3 аж ахуйн нэгж 34 дүгээр хорооны “Баянгол” булагт хамгаалалтын бүс хийж, өөрийн талбайд нийт 100 мод тарьж арчлан ургуулж байна. Нийслэлийн Байгаль орчны газраас төслийн гүйцэтгэгчээр ажиллаж буй 4 аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж 90-98.6 хувьтай гэж дүгнэсний дагуу байгаль орчны нөхөн сэргээлтийн тухайн оны барьцаа мөнгө буцаан олголт хийгдсэн. Газрын хэвлийн тухай хуулийн 15.3 дахь заалтын хүрээнд 7 зүйл 37 заалттай “Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулах журам”-ын төсөл боловсруулж ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	20.0

81	4.1.10.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг өргөжүүлэн, хувийн хэвшлийн байгууллагыг дэмжин ажиллана.	Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг өргөжүүлэн, хувийн хэвшлийн байгууллагыг дэмжих зорилгоор хавар, намрын мод тарих арга хэмжээний үеэр нийтийн эзэмшлийн талбайд мод тарих, хог цэвэрлэсэн талбайд “Ойн зурвас байгуулах” зэрэг ажлын хүрээнд 15 нэр төрлийн нийт 40,648 ширхэг мод, бут, сөөгний тарьц суулгацыг 15 байгууллагатай худалдах, худалдан авах гэрээг байгуулан мод худалдан авалтыг зохион байгуулан ажилласан.	20.0
4.2.Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.			
82	4.2.1.Айл өрхийн дулаан хангамжийг төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан хангамжид үе шаттай шилжүүлж, дулаан алдагдлыг бууруулна.	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 10 гэр хорооллын 11,772 айл өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшинд шилжүүлэх ажил 2026 онд хийгдэнэ. 2025 онд ногоон бүсийн айл өрхүүдийн байшин сууцны дээвэр, цонх, гадна фасадын дулаалгын төрөл хэмжээ, гэр сууцны ханын хэмжээг нарийвчлан гаргах судалгааны ажлыг нийслэл, дүүргийн нутгийн захиргааны болон хэлтэс албадын нийт 320 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж 14,209 айл өрхийг судалгаанд хамруулсан.	05.0
83	4.2.2.Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрхүүдэд 5кВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны цахилгаан эх үүсгүүр суурилуулж, агаар хөрсний бохирдлыг бууруулна.	Сэргээгдэх эрчим хүчинд түшиглэн гэр хорооллын айл өрхийн эрчим хүчний шилжилтийг нарны эрчим хүчээр хийх, технологийн шийдлээр шийдэх төслийг “Юрика” ХХК болон “Гэр-Өргөө” ХХК-тай хамтран 6, 7, 8, 23, 26, 36 дугаар хороодын 1351 өрхийн судалгааг авч төслийн багт хүргүүлсэн.	05.0
84	4.2.3.Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, сайжруулсан шахмал түлшний хэрэглээг бууруулна.	“Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгөх” сургалтыг гэр хорооллын 33 хорооны 240 хэсгийн ахлагч нарт зохион байгуулж, 47,250 ширхэг гарын авлага, зөвлөмжийг айл өрхүүдэд тараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын нийт 3969 албан хаагчид, 36 гэр хорооллын 57,059 өрхийн халаалт болон зуухны судалгааг цахимаар QR код уншуулан авч, зөвлөгөө мэдээлэл хүргэн гарын авлага тараасан. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор угаар мэдрэгчгүй 4043 айл өрхүүдэд угаарын хийн мэдрэгч хүлээлгэн өгсөн. Сайжруулсан шахмал түлшний картны давхардлыг арилгах зорилгоор “Хотула” программыг нэвтрүүлж, статистикийн үндэсний хороотой хамтран нэг өрхөд 1 эрх журмын хэрэгжилтийг ханган ажиллаж 100,000 гаруй байсан түлшний картны давхардлыг арилгаж, 50,000 гаруй өрхийн эрхийг сэргээсэн. Дүүргийн хэмжээнд гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, хабитат төсөл, үерийн аманд буусан өрхүүд, дахин төлөвлөлт, сэргээгдэх эрчимд холбогдсон шалтгаанаар нийтдээ 58,277 яндантай өрхөөс 390 ширхэг яндантай өрхөөр буурсан.	25.0

4.3.Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг иргэдийн оролцоотой хамтран санал санаачилга гарган ажиллана.			
85	4.3.1.Хөрсний бохирдлыг бууруулах олон талт арга хэмжээг зохион байгуулна.	Гэр хорооллын 33 хорооны 62,435 өрхийн 45,592 нүхэн жорлон, 9981 бохирын цооног орчмын 227,960 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг “Орхон-Овоот” ХХК нь хийж гүйцэтгэсэн. “Шинэ-ариусгал” ХХК 43 хорооны нийтийн эзэмшлийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, автобусны буудал, үерийн гуу жалганы нийт 360,000 м2 талбайд мананцартай ариутгалыг хийсэн. Дахин төлөвлөлтөд орсон 390 өрхийн 174 ариун цэврийн байгууламжийг буулгасан.	20.0
86	4.3.2.Гэр хорооллын 20,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	"Захиалагчийн алба" ОНӨААТҮГ нь гэр хорооллын хорооны 3000 айл өрхийн нүхэн жорлонг шинээр солих ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Нийт 29 хороонд 58 удаагийн сургалт зохион байгуулж, 3000 ширхэг гарын авлага тараан, 2720 айл өрхтэй гэрээ байгуулж, 2720 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэн, сайжруулсан ариун цэврийн байгууламж суурилуулах ажлыг 20 машин механизм, 33 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэж байна.	25.0
4.4.Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, орчны бохирдлыг бууруулах эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.			
87	4.4.1.Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх эдийн засгийн эргэлтэд оруулахад төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх дундын бичил төвийг байгуулахаар газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн болно.	10.0
88	4.4.2.Гудамж талбайн цэвэрлэгээ, хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээнд тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр парк шинэчлэлийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн төсвийн санхүүжилтээр хятад улсын 2 шүүрний машин, 2 шахдаг машин, 14 ширхэг олон үйлдэлт гар төхөөрөмж, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хог тээврийн 13 хово, үүрдэг зориулалтын машин 4, шахдаг машин 2, бобкат 2, шүүрний машин 2, даралтат машинаар зам угаагч 1, давс бодис цацагч машин 2, нийт 32 ширхэг машин, механизм, 14 ширхэг олон үйлдэлт гар төхөөрөмжөөр “Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын парк шинэчлэлтийг хийсэн.	25.0
89	4.4.3.Хог хаягдлыг хүлээн авч ангилан ялгах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, дундын бичил төвүүдийг ажиллуулан хог хаягдлыг цуглуулах далд бункерийн технологийг үе шаттай нэвтрүүлж, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг арчлах хамгаалах иргэдийн бүлгийг ажиллуулна.	Дүүргийн 4-н хорооны нутаг дэвсгэрийн 5 байршилд далд бункер байгуулах ажил 80 хувьтай хийгдэж байна. Нийтийн эзэмшлийн эзэнгүй гудамж, зам талбай, гуу жалга арчлах иргэдийн бүлгийн 359 иргэнтэй хороодын Засаг дарга хөлсөөр ажиллах гэрээг байгуулан ажиллуулсан. Иргэдийн бүлэг нь давхардсан тоогоор 6 сарын турш нийт 6.1 сая м2 талбайн 925,888 тн хог хаягдал, шарилж, луулийг цэвэрлэсэн.	20.0

90	4.4.4.Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах хандлагыг олон нийтийн оролцоотой хэрэгжүүлж, ил задгай орчинд хог хаяхгүй байх дадал зуршлыг өөрчлөн орчны бохирдлыг бууруулна.	Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах хүрээнд “3R4UB” төслийг хэрэгжүүлэгч Италийн үндэсний судалгааны зөвлөл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Цэнгэг ус байгаль хамгаалах төвтэй хамтран 15 сургуулийн 25,000 сурагчийг хог хаягдлыг ангилан ялгах сургалтад хамруулж, тус сургуулиуд эко хогийн цэгтэй болсон. Хог хаягдлыг ангилан ялгах, орчны бохирдлыг бууруулах, ил задгай хог хаягдал хаяхгүй байх чиглэлээр дүүргийн цахим хуудсаар нийт 20 төрлийн постер бэлтгэн иргэдэд хүргэсэн.	25.0
91	4.4.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлж, зуслангийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх журмыг боловсруулж батлуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд заасны дагуу “Хогны гэрээ”-г цахим болгох ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ИМонголиа системийг хэрэгжүүлэгч Egegee хөгжүүлэлтийн баг болон дүүргүүдийн төлөөлөл хамтран сургалт зохион байгуулж “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх хамтран ажиллах гэрээ”-ний загвар боловсруулан ажиллаж байна.	10.0

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

5.1.Засаглал, цахим шилжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

92	5.1.1.Засаг захиргааны нэгжийн удирдлагын хувьд эрх мэдэл, төсөв санхүүгийн хувьд нэгдмэл удирдлага бүхий дүүрэг, 43 хороог 4 хот, 14 хороолол, 1 дагуул хот болгож өөрчлөх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Сонгинохайрхан дүүргийг 4 хот, 1 дагуул хот, 10 хороололтой болох төлөвлөлтийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2025 оны А/334 дүгээр захирамжаар баталсан. Бэлтгэл ажлын хүрээнд шинээр байгуулах засаг захиргааны нэгжийн бүтэц орон тооны санал, цахим үйлчилгээний судалгааг гаргаж нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Шинээр байгуулагдах хотуудын эдэлбэр газрын хил хязгаарыг тогтоох асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэхтэй холбогдуулан “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолын дагаж мөрдөх хугацааг 2027 оны 01 дүгээр сарын 01 хүртэл хойшлуулсан.	05.0
93	5.1.2.Төрийн үйлчилгээг иргэнд хурдан, шуурхай хүргэж, шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй ил тод болгон үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.	Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй ил тод хүргэхээр дүүргийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/19 дүгээр захирамжаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдол санал хүсэлтэд шуурхай хариу өгөх, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулж, иргэдтэй хийх уулзалтын журмыг баталсан. Удирдлагын иргэдтэй хийх уулзалтыг 12 удаа зохион байгуулж 132 иргэний 146 санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр харьяа байгууллагуудад 12 удаагийн давтамжтай чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн. Дүүргийн хэмжээнд нийт 4494 өргөдөл, гомдол ирснээс судалж байгаа 110, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 4384 байна.	25.0

94	5.1.3.Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилтот төслийг хэрэгжүүлж, зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг зохион байгуулна.	“Төсөл, хөрөнгө оруулалтын мэдээллийн ил тод байдлын систем (SHD Monitoring)” нь дүүрэгт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй хүргэх зорилготой бөгөөд иргэдэд зориулсан мэдээллийн вэбсайт, удирдлагын панел болон ухаалаг утасны аппликейшнийг хөгжүүлэн ашиглалтад нэвтрүүлсэн. Сар бүр мэдээллийн сангийн баяжилтыг хийж байна. Худалдаа, үйлчилгээний 3 төрлийн зөвшөөрлийг Ulaanbaatar.mn хаягаар цахимаар өгч байна.	20.0
95	5.1.4.Төрийн албан хаагчийн чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тодорхойлж, гүйцэтгэлийн үнэлгээ, чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын Тамгын газар, Хороодын зохион байгуулалт бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/179 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газар, Хороодын зохион байгуулалт бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Бүтэц орон тоогоор Засаг даргын Тамгын газар, Хороодод 384 орон тоотой байхаар бүтцийг оновчтой тодорхойлж баталсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, Нийслэлээс хот нийтийн аж ахуйн зарим чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнтэй холбогдуулан ЗДТГ-ын дүрэмд өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан. Засаг даргын Тамгын газар, хороодын төрийн албан хаагчдын 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, хөдөлмөрийн гэрээний үр дүнг тооцсон. Төрийн албаны Мерит зарчмын хүрээнд анхан шатанд ажиллаж байсан 5 албан хаагчийг шатлан дэвшүүлж Тамгын газарт томилсон. Тамгын газраас дээд шатны байгууллага руу 4 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан байна.	20.0
96	5.1.5.Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, тасралтгүй хөгжүүлж сургах, ажиллах нөхцөл орчныг сайжруулах, техник тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтот “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны төсөл”-ийг хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны төсөл”-ийг дүүргийн Засаг даргын 2025 оны “Төсөл батлах тухай” А/140 дүгээр захирамжаар баталж, 2025 онд 5 зорилт 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлт 83 хувьтай байна. Олон жил үр бүтээлтэй ажилласан 27 албан хаагчдад орон байрны нөхцөл сайжруулахад нь зориулж 389.6 сая төгрөг, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 10 албан хаагчдад 39.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Дүүргийн ЗДТГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөөг “Албан хаагчдыг сургалтаар хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд 10 заалттайгаар баталсан. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, дунд хугацааны давтан сургалтад улсын төсвийн санхүүжилтээр 2 албан хаагчийг, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны 40 цагийн сургалтад 44 албан хаагч, Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А3 сертификат олгох сургалтад 27 албан хаагчийг тус тус хамруулсан. Эрэлттэй мэргэжил эзэмшихээр их, дээд сургуульд бакалаврын болон магистрын ангид элсэн суралцаж байгаа Тамгын газар, хороодын мэргэжилтэн 30 албан хаагчдад 34.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. 2024	25.0

		<p>онд Их засаг Шинжлэх ухааны сургуульд Эрх зүйн мэргэжлээр 42 албан хаагч, 2025 онд 26 албан хаагч эхний жилийн сургалтын төлбөрийн 20 хувийн хөнгөлөлттэйгөөр элсэн суралцаж байна. Сургалт хүний нөөцийн хөгжлийн төв, бусад байгууллагын сургалтад 251 албан хаагч хамрагдсан. Албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах хүрээнд Менежерийн ажлын албыг тусад нь гаргаж ЗДТГ-ын 3 дугаар байрыг ашиглалтад оруулсан. Мөн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад зориулан дүүргийн төсвийн хөрөнгөөр 36 нэр төрлийн 89 ширхэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, 18 хороонд 53 нэр төрлийн 81 ширхэг тоног төхөөрөмж, Ахмадын хороонд 7 нэр төрлийн 10 ширхэг тоног төхөөрөмжийг дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, хүлээлгэн өгсөн байна.</p>	
97	<p>5.1.6.Төрийн албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалтанд ёс зүйн зөрчил, авлигын эсрэг сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2025 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/368 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 16 арга хэмжээтэй баталж, дүүргийн төр захиргааны нийт байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. Хэрэгжилт 85 хувьтай байна. 2025 онд Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын удирдах болон эрх бүхий 62 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлсэн. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлагыг төлөвшүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлье” сургалтыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр захиргааны байгууллагуудын удирдах, гүйцэтгэх 650 гаруй албан хаагчдыг хамруулж зохион байгуулсан. Мөн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 6 байгууллага урьдчилан сэргийлэх сургалтыг байгууллагадаа зохион байгуулж 300 албан хаагчийг хамруулсан байна. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх 12 төрлийн постер, хууль тогтоомжийг таниулах чиглэлээр 2 удаагийн богино бичлэгийг бэлтгэн олон сувгаар төрийн албан хаагч, иргэд олон нийтэд түгээн ажилласан.</p>	25.0
98	<p>5.1.7.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>“Авлигын эсрэг нэгдье” 1 сарын аяныг дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 23 байгууллагуудын дунд зохион байгуулж авлигыг үл тэвчих хандлагыг төлөвшүүлж, урьдчилан сэргийлэх ажлуудыг байгууллага бүр зохион байгуулж ажиллалаа. Нийтийн мэдээлийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу ЗДТГ-ын холбогдох 164 мэдээллийг улирал бүр shilen.gov.mn сайтад оруулж ил тод, нээлттэй байдлыг хангасан. Мөн байгууллагын цахим хуудсанд иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах талбар үүсгэж, 70173317 тусгай дугаарын утас ажиллуулж иргэдийн санал хүсэлт өгөх асуудлыг хялбарчилсан.</p>	25.0

99	5.1.8.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулна.	Дүүргийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 3 байгууллага 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны сайтад 405 мэдээллийг байршуулахаас 391 мэдээллийг хуулийн хугацаанд, 14 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Мэдээлэл хоцроон байршуулсан санхүүгийн ажилтанд сануулга өгч ажилласан. Гүйцэтгэл 96.5 хувьтай. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын хүрээнд “Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ, “Сонгинохайрхан амралт цогцолцорын газар” ОНӨААТҮГ, “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ-уудын төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын үйл ажиллагаанд 2025 оны 10 дугаар сарын 09-өөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.	20.0
100	5.1.9.Техник технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээ мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэн иргэдийн мэдэх эрхийг хангана.	Дүүргийн цахим сайтыг шинэчлэн www.shd.ub.gov.mn болгосон. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын алба, хэлтэс, дэргэдэх байгууллагуудын цахим сайт болон facebook хуудас шинэ сайт руу холбогдсон, иргэдийн санал хүсэлтийг давхар хүлээн авах боломж бүрдсэн. “Сонгинохайрхан мэдээ” Facebook цахим хуудсыг ажиллуулж дагагчдын тоог 72000 болгож нэмэгдүүлээ. “Хөгжилд миний оролцоо” нэвтрүүлгийн 33 дугаар, “Эмч зөвлөж байна” нэвтрүүлгийн 40 дугаар, фото мэдээ 350, богино хэмжээний бичлэг 310, постер 800 ширхгийг бэлтгэн цахим хуудсандаа байршуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан байна.	25.0
101	5.1.10.Нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг цахимжуулан “ХУРДАН ЦЭГ”-ийн хүртээмж, “E-MONGOLIA” портал сүлжээний хэрэглээг олон нийтэд сурталчилж, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	Дүүргийн хэмжээнд “Хурдан цэг”-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 18 хороонд “Хурдан цэг” нэмж байгуулсан бөгөөд 384.0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг дүүргийн 43 хороонд угсарч суурилуулсан. Төрийн үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 43 хорооны “Хурдан цэг”-ийн үйл ажиллагааг хянаж, 32 хороонд 43 байгууллагын 453 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Толгойт, Тахилт, Баруун салаа, Содон хороолол зэрэг алслагдсан болон хүн ам шигүү суурьшсан байршилд хөдөлгөөнт “Хурдан цэг”-ийг түр хугацаанд байршуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажилласан. “E-MONGOLIA” портал сүлжээний хэрэглээг олон нийтэд сурталчилах чиглэлээр мэдээ танилцуулга бэлтгэж дүүргийн сайтаар тогтмол түгээж байна.	25.0
102	5.1.11.Нутгийн захиргааны байгууллагын албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулна.	Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 24 байгууллага, Орон нутгийн өмчит-4, Эмнэлэг-2, цэцэрлэг-72, сургууль-30, хороо-43, нийт 175 байгууллагын албан хэрэг хөтлөлт бүрэн цахимжиж, тоон гарын үсэг ашиглаж байна. Албан хаагчдын компьютерийг домэйн хаягт оруулан Lansweeper системд бүртгэж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган удирдлагын нэгдсэн орчинг бүрдүүлээд байна.	25.0

103	5.1.12.Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэл, архивын хэлтсийн байр барьж, “Салбар архив” байгуулах ажлыг эхлүүлнэ.	2025-2026 оны улсын төсөвт санхүүжилт суугаагүй тул Улсын бүртгэл, архивын хэлтсийн барилгын ажил хойшлогдсон. Дүүргийн “Салбар архив” байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн дүүргүүдэд салбар архив байгуулах тухай” А/1516 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжаар Архивын тасгийг “Архивын хэлтэс” болгож бүтцийн өөрчлөлт хийсэн. Салбар архивын үйл ажиллагааны нийтлэг журмын дагуу төрийн архивын хөмрөг үүсгэгч байгууллага Салбар архив байгуулахад тавигдах шаардлагыг хангаж, сан хөмрөг бүрдүүлэх эх үүсвэрийг тодорхойлж, архивын баримт хадгалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан байр, өрөө тасалгааг байгуулж, салбарын орон тоог тодорхойлон, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэх, хадгалах, ашиглах, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.	10.0
104	5.1.13.Салбар архивд хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлж иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн Архивын сан хөмрөгт 138 хөмрөг үүсгэгчийн 13913 цаасан суурьтай баримт, тусгай төрлийн 421 баримт хадгалагдаж байна. Цахим мэдээллийн санд Засаг даргын тамгын газрын захирамжлалын 379 хадгаламжийн нэгж, 37615 хуудас, байнга хадгалах 204 хадгамжийн нэгж байна. Салбар архивын сан хөмрөг дэх цаасан суурьтай баримтаас 2025 онд 9 хөмрөгийн 16 дансны 139 хадгаламжийн нэгжийн 5126 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүссэн мэдээллийн сангаас архивын лавлагаа, мэдээллийг 59 иргэн, хуулийн этгээдэд олгож байна.	25.0
105	5.1.14.Толгойт бүсийн иргэдэд Улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Сонгинохайрхан дүүргийн Толгойт бүсийн иргэдийн бүртгэлийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагыг хүртээмжтэй, хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор Толгойт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 10 дугаар сарын 10-ны өдрөөс Улсын бүртгэлийн салбар үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус салбарт улсын ахлах бүртгэгч 1, иргэний улсын бүртгэгч 3, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 1 нийт 5 албан хаагчтай бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.	25.0
106	5.1.15.Зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2025 оны А/569 дүгээр захирамжаар зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулах аяныг 1 сарын хугацаанд зохион байгуулж, 19 хүүхдэд төрсний гэрчилгээ, 16 насанд хүрч байгаа 85 хүүхдэд шинээр иргэний үнэмлэх, амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 96 иргэнд дахин үнэмлэх олгож, нийт 200 иргэнийг бичиг баримтжуулж, төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.	25.0
107	5.1.16.Гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Засаг даргын Тамгын газар нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын Өөртөө Засах Орны Хянган аймаг, Хөлөнбуйр аймгийн Рашаан хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Канбуг, Сонбуг дүүрэг, Япон Улсын Изүнокүни хоттой хамтын ажиллагаатай ажиллаж байна. 2025 онд шинээр Америкийн Нэгдсэн Улсын Потомак Их сургуультай нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын	25.0

		мэргэшлийн түвшин, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор богино хугацааны мэргэшил дээшлүүлэх болон магистрын зэрэг олгох сургалт, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сасан хоттой төрийн захиргаа, эдийн засаг, үйлдвэр, соёл, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, ажлын байр зэрэг харилцан сонирхсон салбаруудад хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр “Санамж бичиг” байгуулсан. Япон Улсын Шизүока мужийн Изүнокүни хоттой хамтын ажиллагаа тогтоосны 10 жилийн ойн арга хэмжээг 2025 оны 8 дугаар сард Монгол Улсад, 10 дугаар сард Изүнокүни хотод зохион байгууллаа.	
5.2.Батлан хамгаалах хууль, тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавин, иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.			
108	5.2.1.Батлан хамгаалах, Дайчилгааны тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдийн үүргийн биелэлтэд хяналт, шалгалт хийнэ.	Батлан хамгаалах, Дайчилгааны тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг сурталчлах 7 удаагийн арга хэмжээнд 28 сургуулийн 2450 ахлах ангийн сурагч, 200 оюутан хамрагдсан. Иргэн, хуулийн этгээдийн үүргийн биелэлтийг 6 аж хуйн нэгж, 9000 цэргийн үүрэгтнүүдэд хяналт, шалгалт хийсэн.	25.0
109	5.2.2.Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн алба хаах үүргийн биелэлтийг хангуулах, дайчилгааны болон томилгоот нэгжийн сургалт, дадлагын ажлыг зохион байгуулж, нөөцийн чадавхыг нэмэгдүүлнэ.	2025 оны цэргийн бүртгэл 87.8 хувь, нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын хяналтын тоон даалгаврыг 100 хувь, дайчилгааны бэлтгэл нөөцийн давтан сургалт 100 хувь, 8 ангийн 26 командын тодотголыг 100 хувь, “цугларах”, “шилжүүлэх” байрын дадлага, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлтэй тэмцэх суман”, “Оюутан цэрэг”, цэргийн дүйцүүлэх алба хаагчдын сургалт, дадлагыг тус тус хэрэгжүүлсэн. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдээр 452.4 сая төгрөгийг төлүүлсэн.	25.0
110	5.2.3.Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	Өрхийн эрүүл мэндийн төв, “Гарьд манлай” эрэгтэйчүүдийн эмнэлэг, “Ач” эмнэлэгтэй хамтран цэргийн насны залуусыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Цэргийн албанд өвчний учир тэнцээгүй 672 залуучуудыг дүүргийн ЭМТ, ӨЭМТ-үүд эрүүлжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж 141 иргэн эрүүлжиж эрүүлжилтийн хувь 20.9 хувь, цэргийн насны 2985 залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан.	15.0
5.3.Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн байгууллага, албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
111	5.3.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, гудамж,	Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл өсч байгаа хороодод гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, бэлэн байдлыг ханган зөөврийн “Пост” байршуулж ажиллаж байна. Гэмт	25.0

	<p>зам талбай, гэмт хэргийн эмзэг цэгийг хянах “Камерын хяналтын дэд төв”-ийг ашиглалтад оруулж, камерын хяналт бүхий “Ногоон бүс” байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	<p>хэргийг буруулах ажлын хүрээнд “Аюулгүй орчин” аян зарлаж урьдчилан сэргийлэх ажлыг 5 чиглэлээр зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага иргэн аж ахуйн нэгжид шаарлага-112, зөвлөмж-78 тус тус өгч үр дүнг тооцож, шаардлага биелүүлээгүй 4 иргэн, 3 албан тушаалтныг нийт 5.3 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Теле камерын хяналтын дэд төв” 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус төвд өнөөдрийн байдлаар дүүргийн Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтсээс тус бүр нэг албан хаагч 24 цагаар ажиллаж байгаа бол Нийслэлийн мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс нэг ажилтан дуудлага, мэдээллийг тухай бүр шууд хүлээн авч, холбогдох байгууллагад цаг алдалгүй мэдэгдэн ажиллаж байна. “Теле камерын хяналтын дэд төв”-д нийт 165 ширхэг камер бүртгэлтэй байгаагаас хэвийн ажиллагаатай 133 ширхэг камер байна. Камерын хяналт бүхий “Ногоон бүс” байгуулах ажлын хүрээнд дүүргийн 12, 18, 33 дугаар хороодыг камержуулах ажлын зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.</p>	
112	<p>5.3.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авто замын ачааллыг бууруулахад чиглэсэн хөдөлгөөн зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, 15 цэгт, 2 ээлжээр нийт 65 алба хаагч тогтмол үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Замын цагдаагийн цагдаагийн албан хаагчид дунд “Цамба-Уриалга” Viber групп үүсгэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг мөрдүүлж, иргэд, олон нийттэй зөв боловсон харьцаж, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар уриалгад нэгдэн, түргэн шуурхай ажиллаж байна. Тайлант хугацаанд гудамж, замын хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1711, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1294 зөрчлийг илрүүлэн нийт зөрчил гаргасан 90,590 жолоочийг 2.1 тэрбум төгрөгөөр торгох арга хэмжээг авч хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажилласан. Эргүүлийн чиглэл, харуулын цэгт үүрэг гүйцэтгэх алба хаагчдын чиг үүргийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 12 цэгт, 2 ээлжээр нийт 41 алба хаагч тогтмол үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p>	25.0
113	<p>5.3.3.Дүүргийн 21, 40 дүгээр хороонд гал түймэр унтраах, аврах анги байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.</p>	<p>Дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд 1.1 га талбайд шинээр Гал түймэр унтраах, аврах 82 дугаар анги байгуулах ажил нь нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, барилгын гүйцэтгэгчээр “Эй Эс Эс инженеринг” ХХК шалгарч барилгын газар шороо, бэлтгэл бетоны ажил бүрэн хийгдсэн суурь цутгалт, карказ угсаралтын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 30 хувьтай хуваарийн дагуу явж байна.</p>	50.0

		<p>Дүүргийн 40 дүгээр хороонд шинээр “Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр анги”-ийг шинэчлэн байгуулах ажил нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байна. Барилгын гүйцэтгэгчээр “Энигма” ХХК ерөнхий карказ, бүтэцийг бүрэн хийсэн, барилгын гадна, дотор засварын ажлын гүйцэтгэл хангалтгүй барилгын ажил хойшлогдон тул гэрээг 3 удаа сунгасан. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.</p>	
114	<p>5.3.4.Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулна.</p>	<p>Онцгой байдлын хэлтсээс энэ онд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ангиллын сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Оюутан, сурагчдын сургалтыг 33 удаа; • Иргэдийн сургалтыг 23 удаа; • Удирдах ажилтны сургалтыг 5 удаа; • Мэргэжлийн ангийн сургалтыг 8 удаа; • Ажилтан алба хаагчийн сургалтыг 343 удаа нийт 412 удаагийн сургалтыг зохион байгуулж, 18,945 хүнийг хамруулсан. Ангиллын сургалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.6 хувиар өссөн. <p>Гал түймэр, гоц халдварт өвчин, Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 253 удаа давхардсан тоогоор 3,256 алба хаагчдыг хамруулж, 102,674 айл өрх, 189,326 иргэнд урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг хүргүүлсэн. Сэргийлье, сэрэмжлье, галлахдаа анхаарья нөлөөллийн ажлын хүрээнд 78 контентийг бүтээж, 168,913 иргэнд түгээсэн. Нийт 38 аж ахуй нэгж, байгууллага, 109-н сургууль, цэцэрлэгт гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, зөвлөмж, төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах зорилгоор Сонгинохайрхан дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн зардлаар ой хээрийн түймрийн үед ашиглах туулах чадвар сайтай “Танк 300” автомашин, үерийн үед хүн хүч багаж хэрэгслийг зөөвөрлөх давхар кабинтай “Портер” автомашин, шалган нэвтрүүлэх товчоодод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад “Хөдөлгөөнт удирдлагын байр”, үерийн үед ашиглах “Угсардаг далан” зэргийг шийдвэрлэсэн. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс үер ус, халиа тошин хүндэрсэн үед ашиглах нураагч модок, мөсний гинжин хөрөө, мөрөвчтэй усны гутал, гар багаж /хүрз, лоом, жоотуу/ зэргийг тус тус шийдвэрлэсэн. Сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор офицер бүрэлдэхүүний сургалтыг 5, ахлагч бүрэлдэхүүнд 30, төрөл мэргэжлийн сургалтыг 5, тактик тархалтын сургалтыг 144 удаа тус тус зохион байгуулж нийт давхардсан тоогоор 2700 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдын Хууль, эрх зүй, цэргийн хэргийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг цахим хэлбэрээр нийт 4 удаа авч давхардсан тоогоор 260 алба хаагч хамрагдсан.</p>	25.0

115	5.3.5.Хууль, хяналтын байгууллагын байр, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.	Хууль, хяналтын байгууллагын байр, барилга байгууламжийн засвар үйлчилгээний чиглэлээр дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн байрны дээвэр, гадна фасад засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хууль, хяналтын байгууллагын алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр: <ul style="list-style-type: none"> • 32 ширхэг иж бүрэн компьютер, 4 ширхэг өнгөт принтер, 32 ширхэг оффис ширээ, 32 ширхэг сандал, • Зөөврийн пост зэргийг шийдвэрлэж ажилласан. 	25.0
116	5.3.6.Мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэд, олон нийт, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, тэдний оролцоог нэмэгдүүлнэ.	Хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээний хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хороодын хөгжлийн нийгмийн ажилтнууд болон хэсгийн ахлагч нарт “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” сургалт, хэлэлцүүлгийг Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран танхимаар болон цахим сургалтыг зохион байгуулж нийт 422 албан хаагчдыг хамруулсан. Нийслэлийн захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдийн шүүх хуралдаанд оролцох ач холбогдлыг таниулах, тэдгээрийн идэвхийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж 34 иргэнд хамрагдсан. Мэйжик Эй Эм Ди ХХК-тай хамтран хүүхэд болон насанд хүрсэн иргэдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор теле контент, богино хэмжээний видео 2, постер 1-ийг гарган нөлөөллийн ажлууд хийгдэж байна.	25.0
НИЙТ ДҮН:			22.6